

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2023-2027



АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	v
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	vi
БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	1
1.1. АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА	1
1.2. АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ НАР	3
БҮЛЭГ 2. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТАНИЛЦУУЛГА	4
2.1. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН МАНДАТ, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.2. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ТҮҮХЭН ТОВЧОО	5
БҮЛЭГ 3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АРГА ЗҮЙ	8
3.1. М.БРАЙСОНЫ СТРАТЕГИ УДИРДЛАГЫН ЗАГВАР	8
3.2. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН НЭЭЛТТЭЙ СИСТЕМИЙН ЗАГВАРЧЛАЛ	9
3.3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ “ABCD” ЗАГВАР	10
3.4. БАГЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТИЙН АРГА ЗҮЙН ЗААВАР-ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ISO21502	11
3.5. ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	12
БҮЛЭГ 4. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН ГАДААД НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА	13
4.1 УЛС ТӨРИЙН ОРЧНЫ СУДАЛГАА	13
4.2 ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫ СУДАЛГАА	14
4.3 ЭКОНОМЕТРИК ШИНЖИЛГЭЭ	17
4.4 НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧИН	20
4.5 БАРИЛГЫН САЛБАРЫН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	23
4.6 ХУУЛЬ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА	26
4.7 БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН НӨЛӨӨ	29
БҮЛЭГ 5. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН ДОТООД НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА	30
5.1 МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАМЖИЙН СУДАЛГАА	30
5.2 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН СТРАТЕГИЙН БЭЛЭН БАЙДЛЫН СУДАЛГАА	32
БҮЛЭГ 6. НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН	38
6.1 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ГАДААД, ДОТООД СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ, СТРАТЕГИЙН ТОМЪЁОЛОЛ	38
6.2 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ХЭЛТЭС НЭГЖ ТУС БҮРИЙН ХАМГИЙН ЧУХАЛ ГОЛ 5 ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ	39
БҮЛЭГ 7. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ХЭЛТЭС НЭГЖҮҮДИЙН ҮНЭТ ЗҮЙЛС	41
7.1 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ХЭЛТСҮҮДИЙН ҮНЭТ ЗҮЙЛС	41
7.2 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН НЭГДСЭН ҮНЭТ ЗҮЙЛС	43
БҮЛЭГ 8. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ҮНЭТ ЗҮЙЛСЭД ТУЛГУУРЛАСАН ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА	44
БҮЛЭГ 9. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	45
9.1 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ	45
9.2 БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН СОРИЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ	45
9.3 НИЙТИЙН АЖ АХУЙ	46
9.4 БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ	46

9.5	ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТ	47
9.6	БҮС НУТАГ, ХОТ СУУРИНЫ ТӨЛӨВЛӨЛТ	47
9.7	СУРГАЛТ, СУДАЛГАА МЭДЭЭЛЭЛ.....	48
9.8	НОРМ, НОРМАТИВ	48
9.9	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛ	49
9.10	ЗАХИРГАА, УДИРДЛАГА	49
9.11	САНХҮҮ, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР	50
БҮЛЭГ 10. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН		51
10.1	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН.....	51
10.2	БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН СОРИЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	56
10.3	НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	60
10.4	БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	63
10.5	ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	73
10.6	БҮС НУТАГ, ХОТ СУУРИНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	77
10.7	СУРГАЛТ, СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН.....	81
10.8	НОРМ, НОРМАТИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	85
10.9	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН	89
10.10	ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН.....	91
10.11	САНХҮҮ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН.....	95
БҮЛЭГ 11. ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН НЭГТГЭЛ		97
11.1.	ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН НЭГТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД	97
11.2.	МЕНЕЖМЕНТИЙН НЭВТРЭЛТ	98
11.2.1.	Төлөвлөлттэй холбоотой нэвтрүүлэх менежментүүд	98
11.2.2.	Зохион байгуулалттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд	98
11.2.3.	Хүний нөөц, манлайлалтай холбоотой нэвтрүүлэх менежментүүд	99
11.2.4.	Хяналттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд	99
11.2.5.	Хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стандартууд	99
БҮЛЭГ 12. СТРАТЕГИЙН 2023-2027 ОНУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЛОГИК ТОГТОЛЦООНЫ ЗАМЫН ЗУРАГ.....		101
БҮЛЭГ 13. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОРОЛЦООНЫ ДАВТАМЖ		102
13.1.	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС.....	102
13.2.	БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН СОРИЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	102
13.3.	НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	102

13.4.	БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	
	103	
13.5.	ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	104
13.6.	БҮС НУТАГ, ХОТ СУУРИНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	
	104	
13.7.	СУРГАЛТ, СУДАЛГАА МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	105
13.8.	НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	106
13.9.	БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ЗУРАГ ТӨСӨЛ МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ	
	АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	106
13.10.	ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	106
13.11.	САНХҮҮ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ	107
БҮЛЭГ 14. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ		108
ХАВСРАЛТ		109
	ХАВСРАЛТ-1. МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАМЖИЙН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮГНЭЛТ	109
	ХАВСРАЛТ-2. МАКРО, МИКРО ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН НЭГТГЭЛ	120
	ХАВСРАЛТ-3. ГРАФИК ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	121

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Зорилт арга хэмжээний гүйцэтгэл.....	5
Хүснэгт 2. Мандатыг хэрэгжүүлэхтэй холбоотой оролцогч талууд.....	5
Хүснэгт 3. Барилга, бүтээн байгуулалтын хөгжлийн бодлого	13
Хүснэгт 4. Барилга угсралт, их засварын ажил, хувиар	14
Хүснэгт 5. Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар	14
Хүснэгт 6. Орон сууцны бус барилга, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар	15
Хүснэгт 7. Барилгын салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа	20
Хүснэгт 8. Хууль эрх зүйн орчны шинжилгээ	26
Хүснэгт 9. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын чадамжийн үзүүлэлтүүд	31
Хүснэгт 10. Хамгийн чухал хүчин зүйлсийн шинжилгээ	39
Хүснэгт 11. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ хэлтсүүдийн үнэт зүйлс	41
Хүснэгт 12. Хамгийн чухал хүчин зүйлсийн ач холбогдлын эрэмбэ ба үнэт зүйлсийн утга.....	43
Хүснэгт 13. Барилга, байгууламжийн захиалагчийн хяналтын үйл ажиллагааны зорилт	51
Хүснэгт 14. Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн үйл ажиллагааны зорилт	56
Хүснэгт 15. Нийтийн аж ахуйн үйл ажиллагааны зорилт	60
Хүснэгт 16. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зорилт	63
Хүснэгт 17. Зураг төслийн хяналтын үйл ажиллагааны зорилт	73
Хүснэгт 18. Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн үйл ажиллагааны зорилт	77
Хүснэгт 19. Сургалт, судалгаа мэдээллийн үйл ажиллагааны зорилт	81
Хүснэгт 20. Норм, нормативын үйл ажиллагааны зорилт	85
Хүснэгт 21. Барилга, байгууламжийн зураг төсөл магадлалын үйл ажиллагааны зорилт	89
Хүснэгт 22. Захиргаа, удирдлагын үйл ажиллагааны зорилт.....	91
Хүснэгт 23. Санхүү, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилт	95
Хүснэгт 24. Хөгжлийн зорилтын нэгтгэл.....	97
Хүснэгт 25. Төлөвлөлттэй холбоотой нэвтрүүлэх менежментүүд	98
Хүснэгт 26. Зохион байгуулалттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд.....	98
Хүснэгт 27. Хүний нөөц, манлайлалтай холбоотой нэвтрүүлэх менежментүүд.....	99
Хүснэгт 28. Хяналттай холбоотой нэвтрүүлэх менежментүүд.....	99
Хүснэгт 29. Хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стандартууд	99
Хүснэгт 30. Барилга, байгууламжийн хэлтсийн оролцооны давтамж.....	102
Хүснэгт 31. Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн стратегийн төлөвлөгөөний оролцооны давтамж	102
Хүснэгт 32. Нийтийн аж ахуйн хэлтсийн стратеги төлөвлөгөөний оролцооны давтамж	102
Хүснэгт 33. Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтсийн стратеги төлөвлөгөөний оролцооны давтамж.....	103
Хүснэгт 34. Зураг төслийн хяналтын хэлтсийн стратеги төлөвлөгөөний оролцооны давтамж	104
Хүснэгт 35. Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтсийн оролцооны давтамж	104
Хүснэгт 36. Сургалт, судалгаа мэдээллийн хэлтсийн оролцооны давтамж.....	105
Хүснэгт 37. Норм, нормативын хэлтсийн үйл ажиллагааны зорилт	106
Хүснэгт 38. Барилга байгууламж, зураг төсөл магадлалын хэлтсийн үйл ажиллагааны зорилт	106
Хүснэгт 39. Захиргаа, удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны зорилт.....	106
Хүснэгт 40. Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсийн үйл ажиллагааны зорилт	107
Хүснэгт 41. Барилгын Хөгжлийн Төв ТӨҮГ-ын гадаад нөхцөл байдлын шинжилгээний нэгтгэл	120
Хүснэгт 42. Эконометрик шинжилгээний дескриптив үр дүн.....	127
Хүснэгт 43. unit root test үр дүн	127

Хүснэгт 44. Корреляцийн шинжилгээний дээлгэрэнгүй үр дүн	127
Хүснэгт 45. Регрессийн шинжилгээний дээлгэрэнгүй үр дүн	128

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Стратеги төлөвлөгөөний үйл явцын загварчлал	8
Зураг 2. Стратеги төлөвлөгөөний нээлттэй системийн загварчлал.....	9
Зураг 3. Стратеги төлөвлөгөөний ABCDE загвар	10
Зураг 4. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл хоорондын хамаарал.....	11
Зураг 5. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц ажлын орчин болон зарчмыг дүрслэн харуулсан зураглал.....	11
Зураг 6. Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар	15
Зураг 7. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөгөөр.....	16
Зураг 8. Барилгын салбарын хүний нөөцийн мэдээлэл	21
Зураг 9. Та бүхэн өөрийн байгууллагын одоогийн бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн дүгнэж байна вэ?	32
Зураг 10. Та байгууллагын нэгж хэсгүүдийн үйл ажиллагааг уялдаа холбоо сайтай гэж дүгнэх үү?	32
Зураг 11. Байгууллагын стратеги үйл ажиллагаа аль чиглэлээр түлхүү хөгжих ёстой вэ?	33
Зураг 12. Үр дүн, гүйцэтгэлийн чанар ямар хэмжээнд байна гэж Та дүгнэж байна вэ?.....	33
Зураг 13. Үр дүн, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхийн тулд бид юунд анхаарлаа хандуулах ёстой гэж үзэж байна вэ?	33
Зураг 14. Байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэхэд юунд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж Та үзэж байна вэ?	34
Зураг 15. Та байгууллагадаа ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байж чаддаг уу?	34
Зураг 16. Ажлын албаны хувьд хөдөлмөрийн бүтээмж ямар түвшинд байна гэж Та үзэж байна вэ?	35
Зураг 17. Байгууллагаас дэвшүүлж буй зорилго, зорилтууд Таны хүлээлт, сонирхол, хэрэгцээ, шаардлагатай нийцдэг үү?	35
Зураг 18. Байгууллагын санхүүгийн чадварыг дээшлүүлэхийн тулд удирдлагын зүгээс юу хийх ёстой гэж Та үзэж байна вэ?	35
Зураг 19. Нэгдсэн программыг ашиглаж, нээлттэй тайлагнаснаар хамт олны идэвх, санаачилга дээшилнэ гэж Та үзэж байна уу?	36
Зураг 20. Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн худалдан авалт, хүрэлцээ хангамж, хэрэглээ ашиглалт хангалттай гэж Та дүгнэх үү?	36
Зураг 21. Ажилтнуудын нийгмийн хангамж, урамшуулал идэвхжүүлэлт ямар түвшинд байна гэж Та үздэг вэ?	36
Зураг 22. Таны хувьд урамшуулал идэвхжүүлэлтийн ямар хэлбэрийг илүүд үзэх вэ?	37
Зураг 23. Стратегийн 2023-2027 онуудад хэрэгжүүлэх хөгжлийн логик тогтолцооны замын зураг.....	101
Зураг 24. График шинжилгээний үр дүн.....	121

БҮЛЭГ 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг нь “Барилгын хөгжлийн төв” Төрийн өмчит үйлдвэрийн газрын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийх, стратегийн менежментийг сайжруулах арга замыг тодорхойлон төлөвлөгөө боловсруулах зорилго дэвшүүлж ажилласан. Зорилгын хүрээнд шууд ба шууд бус нөлөөлөх макро, микро орчин болон байгууллагын дотоод орчны судалгаа, шинжилгээг гүйцэтгэн үнэлгээ өгч нэгдсэн дүгнэлт гаргасан. Хөгжлийн хандлагыг авч үзвэл, дараах байдалтай байна. Үүнд:

- Монгол улсын газар нутгийн 0.3%-ийг эзэлдэг Улаанбаатар хотод нийт хүн амын 47.6% нь амьдарч байна. Мөн орон нутагт төвлөрөл бүхий суурин газруудыг хөгжүүлэх бодлого хэрэгжиж байна. Хүн амын төвлөрлөөс үүдэн агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг олон хүндрэл тулгарч байна. Хот суурин газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж орчин үеийн шийдэл бүхий, нийгэм эдийн засгийн үр өгөөжтэй, иргэндээ ээлтэй байдлаар хөгжүүлэхээр Улсын их хурлаас 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” баримт бичигт Улаанбаатар хот ба дагуул хотуудыг хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн. Түүнчлэн Улсын их хурлаас 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус хэлэлцэн баталсан.
- Барилга, хот байгуулалтын яамны стратеги төлөвлөгөөг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/133 дугаар бүхий Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан боловсруулсан. Ажлын хэсэг тус яамны ерөнхий, үндсэн, нийтлэг чиг үүргийн хүрээнд 21 зорилт, 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2020-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан. Энэхүү төлөвлөгөөг “Барилгын хөгжлийн төв ТӨҮГ”-ын бодлого баримт бичигт тусгаж ажиллах нь зүйтэй гэж үзсэн. Барилга, хот байгуулалтын салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөнд Барилгын Хөгжлийн Төв ТӨҮГ-тай холбоотой 4 бүлэг ажлын 11 ажил, Салбарын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 20 арга хэмжээ гүйцэтгэхээр тусгасан байна.
- Барилга, хот байгуулалтын салбарын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хуулийг хэрэгжүүлэх норм, норматив, дүрэм журам, технологи, стандартыг зайлшгүй шинжлэн сайжруулах шаардлага тулгамдаж байна.
- Барилгын болон аж үйлдвэрийн, бусад салбарыг хөгжүүлэхийн тулд дэд бүтцийг орон нутагт бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, төсвийн зарцуулалтыг оновчтой болгох гэх мэт олон арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
- Барилга, хот байгуулалтын салбарт дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн эргэлт удааширч, бодит хөрөнгө оруулалт буурсан. Түүнчлэн хоёр хөрштэй холбоотой хил гаалийн хүндрэлээс үүссэн бараа материалын үнийн өсөлт нь тус салбарын бүтээмжийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсээр байна.
- Хүн амын худалдан авах чадвар буурч, бодит орлого инфляцитай уялдаж чадахгүйгээс гадаад оронд ажиллах сонирхолтой иргэдийн тоо нэмэгдсээр байна. Энэ нь барилга, хот байгуулалтын салбарын ажиллах хүчний байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Иймд барилгын салбарт технологийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий болжээ.
- Өнөө үед робот, хиймэл оюун ухаан, блокчейн, нанотехнологи, квант компьютер, биотехнологи, зүйлсийн интернэт, 3D принтер, автомат жолоодлого гэх мэт “Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал” -ын төрөл бүрийн дэвшилтэт технологиудыг ашигласнаар барилга, бүтээн байгуулалтын салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дэлхий даяар анхаарлаа хандуулж байна.
- Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд нийгэм эдийн засгийн сөрөг нөлөө давамгайлснаас гэр хорооллыг дахин төлөвлөлтөд оролцох аж ахуйн нэгжүүдийн сонирхол

буурсан байна. Түүнчлэн баригдаж буй барилгын материалын чанар, эрсдэлд тэсвэрлэх чадварын үнэлгээ нь стандарт түвшнээс зарим тохиолдолд доогуур байгаа нь иргэдийн амь нас, эд хөрөнгөд ноцтой аюул учруулахаар байна.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа шинжилгээ, улс төр, хууль эрх зүйн бодлогын баримт бичгүүдэд үндэслэн тус байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсрууллаа. Тус төлөвлөгөөнд Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын давуу талуудыг бататгахын хамт боломжуудыг ашиглах, сул талуудыг бууруулах замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэх ба тулгарч болзошгүй эрсдэлийг даван туулахад чиглэсэн үйл ажиллагааны чиглэлүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон болно.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолыг баримтлан, Төрийн албаны тухай хуулийн 53-р зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ерөнхий удирдамжийг үндэслэл болгож боловсруулсан болно.

Түүнчлэн энэхүү баримт бичгийг дээрх журмын 2.4.4-т заасан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг мөрдлөг болгон ажилласан.

1.2. АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ НАР

Захиалагч талын багийн ахлагч:

Ц.Амарсанаа. “Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ-ын Дарга

Захиалагч талын багийн гишүүд:

эрхлэгч

О.Одбаяр. Хот байгуулалт, зураг төслийн институтын

Г.Түвшинжаргал. Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Э.Мөнхсүх. Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга

Э.Хангал. Барилга байгууламжийн зураг төсөл, магадлалын хэлтсийн дарга

Д.Батням. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Ж.Энхтуяа. Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн дарга

Т.Ганбаатар. Нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Д.Алтанхуяг. Норм, нормативын хэлтсийн дарга

Н.Амартүвшин. Сургалт, судалгаа мэдээллийн хэлтсийн дарга

Д.Чинзолбоо. Зураг төслийн хяналтын хэлтэс

С.Давааням. Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтэс

Гүйцэтгэгч талын багийн ахлагч:

С.Болдбаатар. *Санхүү, эдийн засагч*

Гүйцэтгэгч талын багийн гишүүд:

Ц.Өнөржаргал. *Менежментийн зөвлөх*

Ш.Жигжид. *Өгөгдлийн шинжээч, эдийн засагч*

Т.Адъяа. *Маркетингийн менежер*

Б.Пүрэвсүрэн. *Хүний нөөцийн менежер*

БҮЛЭГ 2. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТАНИЛЦУУЛГА

2.1. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН МАНДАТ, ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Барилгын Хөгжлийн Төв Төрийн өмчит үйлдвэрийн газар нь 11 хэлтэс нэгжтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Захиргаа, удирдлагын хэлтэс, Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтсээс гадна Барилгын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр дараах хэлтэс нэгжүүд ажиллаж байна. Үүнд:

- Норм, нормативын хэлтэс
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс
- Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс
- Нийтийн аж ахуйн хэлтэс
- Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс
- Барилга, байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтэс
- Бүс нутаг, хот суурины төлөвлөлтийн хэлтэс
- Зураг төслийн хяналтын хэлтэс
- Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори

Барилгын тухай хуульд зааснаар “Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ буюу Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан.

- Барилгын тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;
- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;
- Барилгын салбарын шинжлэх ухаан, техник технологийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Барилгын салбарын ажилтан, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээлээр хангах ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индексийг боловсруулах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлөн оролцох;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх;
- Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл байгуулан, үйл ажиллагааг нь зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээгээр зохион байгуулах;
- Барилгын материалын үйлдвэрлэлийн технологийн зааврыг хянаж, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ нь 2022 онд Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн ба нийт 34 зорилт 70 арга хэмжээ төлөвлөснөөс Бодлогын шинж чанартай ажлын гүйцэтгэл 100%, Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээтэй холбоотой ажлын гүйцэтгэл 96%, Хуулиар

олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 98%-иар тус тус дүгнэгдсэн байна. Эдгээрийг журамд заасан ангиллаар харуулбал:

Хүснэгт 1 Зорилт арга хэмжээний гүйцэтгэл

№	АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	5 зорилт, 10 арга хэмжээ	100%
2	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	11 зорилт, 15 арга хэмжээ	98%
3	Хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	18 зорилт, 45 арга хэмжээ	96%

Дээрх хүснэгтээс үзвэл, тус байгууллага нь зорьсон зорилтоо хангалттай хэмжээнд хийж гүйцэтгэдэг гэж Барилга, хот байгуулалтын яамны дотоод аудитын газрын 2022 оны тайланд тусгагджээ. Гэвч стратеги төлөвлөгөө боловсруулахтай холбоотой тус байгууллагын удирдлага хамт олны хэлэлцүүлгээр сайжруулах, шинээр бий болгохтой холбоотой санал санаачилгууд ихээр гарч байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Мандат нь салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээгээр тодорхойлогддог. Энэ нь алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох ажлын хүрээг тогтоож өгнө.

Хүснэгт 2. Мандатыг хэрэгжүүлэхтэй холбоотой оролцогч талууд

Ерөнхий чиг үүрэг-1: БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Хот байгуулалтын бодлого	Хот байгуулалтын баримт бичигт магадлал хийх	Барилга, хот байгуулалтын яам Аймаг нийслэлийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын хэлтэс Монголын Барилгын Үндэсний Ассоциаци болон салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл Тусгай зөвшөөрөл бүхий Инженер техникийн ажилтнууд
	Хот байгуулалтын норм, нормативын баримт бичгийг боловсруулах ажлыг санхүүжүүлэх, батлах, мөрдүүлэх	
	Хот байгуулалтын мэргэжилтнүүдийг давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулах	
ҮЧҮ-2: Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах	Барилга, хот байгуулалтын яам Аймаг нийслэлийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын хэлтэс Барилгын архитектор, инженерийн мэргэжлийн зөвлөл болон салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй Инженер техникийн ажилтнууд
	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зөвшөөрөл олгох	
	Салбарын үйл ажиллагааны цогц мэдээллийг агуулсан мэдээллийн сан байгуулах	
ҮЧҮ-3: Орон сууц, инженерийн шугам сүлжээ, нийтийн аж ахуйн бодлого	Инженерийн шугам сүлжээний бодлого, хууль тогтоомжийг боловсруулах, батлуулах	Барилга, хот байгуулалтын яам Орон сууц нийтийн аж ахуй удирдах газар Аймаг нийслэлийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын хэлтэс
	Инженерийн шугам сүлжээний үйл ажиллагааг удирдан зохицуулах, хяналт тавих	
	Дэд бүтцийн хангамжийн бодлого боловсруулах хэрэгжүүлэх	

2.2. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ТҮҮХЭН ТОВЧОО

1926 он: Ардын засгийн газрын хурлын 40 дүгээр тогтоолоор “Барилгын хэлтэс” байгуулж, барилга барих, барилгын материал үйлдвэрлэх, зураг төсөл зохиох ажлыг эхлүүлсэн.

1929 он: БНМАУ-ын Засгийн газрын 1929 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 18 дугаар тогтоолоор “Барилгын инженер-техникчдийн товчоон” байгуулсан.

1930 он: “Проммонголстрой” хэмээх хувь нийлүүлсэн барилгын байгууллагыг байгуулсан.

1936 он: БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 45 дугаар хурлын тогтоолоор Худалдаа аж үйлдвэрийн яамны дэргэд “Барилгын техникийн хэрэг эрхлэх газар” байгуулсан.

1937 он: “Барилгын техникийн хэрэг эрхлэх газар”-ыг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 33 дугаар хурлын тогтоолоор “Улсын барилгын трест” болгон өөрчилсөн.

1940 он: Сайд нарын Зөвлөлийн 4 дүгээр тогтоолоор “Барилгын зураг төсөв, төлөвлөгөөний газар”-ыг байгуулсан.

1946 он: “Барилгын материал бэлтгэх газар”-ыг байгуулсан.

1947 он: МАХН-ын төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 60/26 дугаар тогтоолоор “Барилгын хэрэг эрхлэх ерөнхий газар”-ыг байгуулсан.

1957 он: БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 99 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Барилгын хэрэг эрхлэх хороо”-г байгуулжээ.

1960 он: МАХН-ын төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 526/364 дүгээр тогтоолоор “БНМАУ-ын Барилга, эдийн засгийн комисс”-ыг байгуулсан.

1963 он: Барилгын материалын үйлдвэрлэл болох тоосгоны завод, шохойн үйлдвэр, төмөрбетоны завод, аймаг дундын модны үйлдвэр, хүрмэн бетоны завод, УБ хотод анхны байшин үйлдвэрлэх комбинат, мод боловсруулах комбинатуудыг тус тус байгуулсан байна.

1972 он: БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэд “Барилга архитектурын Комисс”-ыг байгуулав.

1981 он: “Барилга архитектурын Комисс”-ыг Барилга-архитектур, техник хяналтын улсын хороо болгон өөрчилсөн.

1986 он: МАХН-ын төв хорооны Улс төрийн товчооны 250 дугаар тогтоолоор БНМАУ-ын Улсын Барилгын хороог байгуулсан

1989 он: БНМАУ-ын Улсын Барилгын хороог Барилгын яам нэртэй болгон өөрчилсөн

1990 он: БНМАУ-ын Засгийн газрын 13 дугаар тогтоолоор Барилга хот байгуулалтын талаар улсын нэгдсэн бодлого явуулах, барилгын салбарын норм, норматив боловсруулах ажлыг зохион байгуулж, тэдгээрийг хянаж батлах үүрэг бүхий “Барилга, хот байгуулалтын комисс”-ыг Засгийн газрын дэргэд байгуулсан.

1992 он: Монгол Улсын Засгийн Газрын 12 дугаар тогтоолоор “Барилга, хот байгуулалтын яам”-ыг байгуулж, “Барилга, хот байгуулалтын комисс”-ыг татан буулгав.

1994 он: Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж “Барилга хот байгуулалтын яам”-ыг татан буулгаж “Дэд бүтцийн хөгжлийн яам”-ыг байгуулсан.

1996 он: Монгол Улсын Засгийн Газрын 300 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Барилга, архитектурын газар” байгуулагдсан. Мөн онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний яамыг татан буулгаж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар”-ыг байгуулсан.

2000 он: “Барилга, архитектурын газар”, “Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар”-ыг тус тус татан буулгаж Монгол Улсын Засгийн Газрын 139 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар” нэртэйгээр байгуулагдсан.

2004 он: Засгийн газрын тухай хуулиар “Барилга, хот байгуулалтын яам”-ыг байгуулсан. Монгол Улсын Засгийн Газрын 201 дүгээр тогтоолоор “Барилга, хот байгуулалт, нийтийн аж

ахуйн газар”-ын суурин дээр “Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв”-ийг байгуулсан байна.

2006 он: Засгийн газрын 2006 оны 37 оны тогтоолоор “Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв”, “Хот байгуулалт” УҮГ, Дэд бүтцийн ажилтны мэргэжил дээшлүүлэх институтийг тус тус татан буулгаж тэдгээрийн чиг үүргийг хэрэгжүүлэх “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв”-ийг байгуулсан.

2007 он: Барилга, хот байгуулалтын сайдын 2007 оны 138 дугаар тушаалаар Барилга захиалагчийн алба байгуулагдав.

2009 он: Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоол, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2009 оны 116 дугаар тушаалаар Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндсэн чиг үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай нэгтгэн Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газар болгон өөрчлөн зохион байгуулагдсан.

Тус Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газрын дэргэд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 23 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн Сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албыг байгуулсан.

2012 он: Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 6 дугаар тогтоолоор Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрыг татан буулгаж, тухайн байгууллагын хэрэгжүүлж байсан барилга, нийтийн аж ахуй, сургалт, судалгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий “**Барилгын хөгжлийн төв**” ТӨҮГ-ыг Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор байгуулсан.

2014 он: Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэдэх Барилга захиалагчийн албадыг тус төвд нэгтгэсэн.


2015 он: Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолоор “Зураг төсөл, эрдэм шинжилгээний институт” улсын төсөвт үйлдвэрийн газрыг тус төвд нэгтгэсэн.

БҮЛЭГ 3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АРГА ЗҮЙ

3.1. М.БРАЙСОНЫ СТРАТЕГИ УДИРДЛАГЫН ЗАГВАР

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ын стратеги төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа нь М.Брайсоны стратеги удирдлагын үйл явцын зураглалд (2004) тулгуурлан боловсруулагдсан.

Зураг 1. Стратеги төлөвлөгөөний үйл явцын загварчлал



3.2. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН НЭЭЛТТЭЙ СИСТЕМИЙН ЗАГВАРЧЛАЛ

Стратеги төлөвлөгөө нь “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын өнгөрсөн, одоо, ирээдүйн төлөв байдлыг системчилсэн байдлаар тодорхойлсон.


Зураг 2. Стратеги төлөвлөгөөний нээлттэй системийн загварчлал



3.3. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ “ABCD” ЗАГВАР

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын стратеги төлөвлөлтийн арга зүй нь ABCDE загварын дагуу төлөвлөгдсөн. Үүнд: *Нэгдүгээрт*, судалгаа, шинжилгээ буюу нөхцөл байдалдаа үнэлгээ өгөх; *Хоёрдугаарт*, ач холбогдол бүхий асуудлуудыг тодорхойлох, төрөлжүүлэх; *Гуравдугаарт*, үйл ажиллагааны төлөвлөлт; *Дөрөвдүгээрт*, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Зураг 3. Стратеги төлөвлөгөөний ABCDE загвар




3.4. БАГЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТИЙН АРГА ЗҮЙН ЗААВАР-ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ISO21502


Олон улсын стандартын байгууллагаас стратеги төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг стандартжуулан хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Эдгээр нь:

- ISO 21500 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Үзэл санаа ба үзэл баримтлал
- ISO 21502 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Арга зүйн заавар
- ISO 21504 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Менежментийн арга зүйн заавар
- ISO 21505 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Засаглалын арга зүйн заавар
- ISO /TR 21506 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Үгсийн сан
- ISO 21508 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Гүйцэтгэлийн зардлын менежмент
- ISO 21511 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл: Ажлын бүтцийн задаргаа

Зураг 4. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц, хөтөлбөр, төсөл хоорондын хамаарал



Зураг 5. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх багц ажлын орчин болон зарчмыг дүрслэн харуулсан зураглал



3.5. ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Эдийн засгийн судалгааны арга нь эдийн засгийн хэлбэрүүдийг танин мэдэж, хязгаарлагдмал нөөцийн талаар олон янзын хувилбар гаргаж, түүнээс сонголт хийж зөв шийдвэр гаргахад чиглэсэн. Дараах аргыг авч хэрэглэв. Үүнд:

1. *Танин мэдэхүйн диалектик арга*: Эдийн засгийн бүх юмс үзэгдэл хоорондоо холбоо хамааралтай бөгөөд байнга өөрчлөгдөн хөгжиж байгаа гэсэн үндсэн дээр судалдаг.
2. *Шинжлэх ухааны хийсвэрлэлийн арга*: Эдийн засгийн тухайн асуудалд нөлөөлдөг олон хүчин зүйлүүдээс хамгийн гол хүчин зүйлийг ялган авч, бусдыг нь тогтмол гэж авч үзэж судална. Хийсвэрлэх замаар эдийн засгийн тодорхой тогтолцоог санаагаараа загварчлан таамаглаж, түүний мөн чанар дотоод уялдаа холбоог нээн илрүүлэх боломжтой.
3. *Математикийн ба статистикийн аргууд*: Математик арга нь эдийн засгийн тодорхой үзэгдлийн хэтийн хандлага, зүй тогтлыг илэрхийлсэн олон хувьсагчтай математик загвар боловсруулж ашиглах боломж олгодог арга. Мөн эдийн засгийн нарийн төвөгтэй олон асуудлыг математик аргаар судалж болох хувилбаруудаас хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч болно. Статистик арга нь эдийн засгийн үзэгдлүүдийн хоорондын холбоо, хамаарал, хөгжлийн зүй тогтлыг тогтооход ашиглана.
4. *Индукцийн арга*: Тус тусдаа байгаа баримтуудыг нэгтгэн дүгнэж, эцэст нь ерөнхий дүгнэлт хийх арга.
5. *Дедукцийн арга*: Дэвшүүлсэн ерөнхий таамаглалыг эдийн засгийн бодит баримт материалаар шалгаж ерөнхий дүгнэлтэд тулгуурлан хэсэгчилсэн тусгай дүгнэлт хийх танин мэдэхүйн арга.
6. *Тоон хүснэгтээр илэрхийлэх арга*: Эдийн засгийн тодорхой юмс үзэгдлийн хоорондын холбоо, хамаарлын өөрчлөлтийг тусгасан тоон үзүүлэлтийн хэлбэртэй байна. Илэрхийллийг хийхдээ тоон болон хүснэгтийн арга ашигласан.
7. *Математик илэрхийлэл*: Энэ нь эдийн засгийн тодорхой үзэгдлийн өөрчлөлтийн зүй тогтлыг тусгасан функц, математик загварын хэлбэртэй байна. Үндсэн оролтын утгуудыг математик илэрхийллээр тооцсон.
8. *Объектын талаас нь судлах арга зүй*: Тухайн эдийн засгийн үзэгдлийг зардлын талаас нь судлах арга зүйг ашигласан.
9. *Субъектийн талаас нь судлах арга зүй*: Тухайн эдийн засгийн харилцаанд оролцож байгаа субъектүүдийн харьцааны талаас нь буюу тухайн бүтээгдэхүүний үнэ цэний талаас нь тооцсон.

БҮЛЭГ 4. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН ГАДААД НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ын гадаад орчны нөхцөл байдлын судалгааг системийн орц, гарцад нөлөөлөх хүчин зүйлсийг PESTLE шинжилгээний хүрээнд авч үзлээ.

4.1 УЛС ТӨРИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Салбарын зорилтуудыг үе шаттайгаар харуулав.

Хүснэгт 3. Барилга, бүтээн байгуулалтын хөгжлийн бодлого

САЛБАРЫН ЗОРИЛТУУД	ҮЕ ШАТ	ЗОРИЛГО	ЗОРИЛТ
ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР ЗОРИЛТ 3.2 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	I үе шат (2020-2030) Худалдан авах чадварт нийцсэн орон сууц	Өрх, гэр бүлийг худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх үе	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бий болгох 2. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх
	II үе шат (2031-2040) Чанартай байр, сууц	Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг сайжруулах үе	Гэр хорооллын нөхцөлийг сайжруулж, хүн амын худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулах
	III үе шат (2041-2050) Тохиллог байр, сууц	Хэрэгцээнд нийцсэн чанартай, тохиллог орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе	Өрх, гэр бүлийг эрэлтэд нийцтэй, худалдан авах чадварт тохирсон, чанартай, тохиллог орон сууцаар хангах
ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР ЗОРИЛТ 3.2 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ	I үе шат (2020-2030) Худалдан авах чадварт нийцсэн орон сууц	Өрх, гэр бүлийг худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх үе	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бий болгох 2. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх
	II үе шат (2031-2040) Чанартай байр, сууц	Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг сайжруулах үе	Гэр хорооллын нөхцөлийг сайжруулж, хүн амын худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулах
	III үе шат (2041-2050) Тохиллог байр, сууц	Хэрэгцээнд нийцсэн чанартай, тохиллог орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе	Өрх, гэр бүлийг эрэлтэд нийцтэй, худалдан авах чадварт тохирсон, чанартай, тохиллог орон сууцаар хангах

Энэхүү судалгааны явцад улс төрийн бодлогын бичиг баримтууд нь салбарын түвшинд төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байх, салбар хоорондын уялдаагүй байх, удирдлага байнга солигдох, нөхцөл байдлыг тайлбарлаж ойлгуулахад цаг их ордог зэрэг бэрхшээлүүд нь дээр дурдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулах магадлал өндөр болохыг удирдлага хамт олны зүгээс сануулж байв.

4.2 ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Барилгын салбар, аж үйлдвэрийн зэрэг салбарыг хөгжүүлэхийн тулд дэд бүтцийг орон нутагт бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, төсвийн зарцуулалтыг оновчтой болгох гэх мэт олон арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Барилга, хот байгуулалтын салбарт дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн эргэлт удааширч, бодит хөрөнгө оруулалт буурсан. Түүнчлэн хоёр хөрштэй холбоотой хил гаалийн хүндрэлээс үүссэн бараа материалын үнийн өсөлт нь тус салбарын бүтээмжийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг цахим систем, аргачлалын дагуу боловсруулж, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, бэлтгэл ажил бүрэн хангагдсан төслүүдийг төсвийн төсөлд тусгасан. Ингэснээр үрэлгэн хөрөнгө оруулалтаас хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт руу шилжих зорилт тавин ажиллаж байна.

2022 онд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр нийт 1335 төсөл хөтөлбөр, арга хэмжээ, барилга байгууламжийг 2,137.0 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Хүснэгт 4. Барилга угсралт, их засварын ажил, хувиар¹

Барилгын төрөл	2018	2019	2020	2021	2022
Барилга угсралт, их засварын ажил, бүгд	100	100	100	100	100
Орон сууцны	33.4	29	34.5	36.3	38.5
Орон сууцны бус	34.9	46.4	33.6	32.1	28.2
Инженерийн барилга, байгууламж	29.5	22.2	29.1	28.9	30.3
Их засварын ажил	2.2	2.4	2.8	2.7	3
Шинээр барьсан болон барьж байгаа барилга, байгууламж - бүгд	97.6	97.7	97.2	97.3	97
Барилга	69.1	75.5	68.1	68.4	66.6
Инженерийн барилга, байгууламж	28.5	22.2	29.1	28.9	30.3

Барилга угсралт, их засварын ажил 2023 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 882.1 тэрбум төгрөг болж, 879.1 (99.7%) тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 3.0 (0.3%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 5. Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар²

Гүйцэтгэгчийн төрөл	2020 I-III	2021 I-III	2022 I-III	2023* I-III	2023* I-III 2022 I-III
	тэрбум төгрөг				хувь
Нийт	591.6	585.1	674.3	882.1	130.8
Дотоодын байгууллага	585.5	580.6	670.3	879.1	131.1
Төрийн	7.3	78.7	17.4	3.9	22.1
Хувийн	577.1	492.0	645.4	870.5	134.9
Гадаадтай хамтарсан	1.1	9.9	7.5	4.8	63.4
Гадаадын байгууллага	6.1	4.5	4.0	3.0	75.4

Барилга угсралт, их засварын ажил 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс


¹ Үндэсний статистикийн хороо /www.1212.mn/

² Үндэсний статистикийн хороо /www.1212.mn/

207.8 (30.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 225.1 (34.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 870.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 208.7 (31.1%) тэрбум төгрөгөөр өссөн бол төрийн байгууллагынх 3.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.6 (88.9%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 4.8 тэрбум төгрөг болж, 2.7 (36.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Энэхүү статистик мэдээлэлд эдгээр барилгын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тодорхой дурдаагүй байна.

Зураг 6. Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар



Энэ оны эхний улиралд барилга угсралт, их засварын ажлын 54.5 хувийг орон сууцны барилга, 39.5 хувийг орон сууцны бус барилга, 4.5 хувийг инженерийн барилга, байгууламж, 1.5 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 9.9 нэгж хувиар, орон сууцны бус барилгынх 7.6 нэгж хувиар өссөн бол инженерийн барилга, байгууламжийнх 17.1 нэгж хувиар, их засварын ажлынх 0.4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 6. Орон сууцны бус барилга, төрлөөр, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Барилгын төрөл	2020 I-III	2021 I-III	2022 I-III	2023* I-III	<u>2023* I-III</u> <u>2022 I-III</u>
	тэрбум төгрөг				хувь
Орон сууцны бус барилга	319.9	253.8	215.2	348.7	162.0
Үйлдвэрийн	133.5	167.3	120.5	203.3	168.6
Худалдаа, үйлчилгээний	20.0	15.9	28.4	32.3	113.6
Эмнэлгийн	12.3	6.7	6.8	8.9	131.9
Сургууль, соёлын	58.0	39.8	30.0	49.2	164.1
Бусад	96.2	24.1	29.5	55.0	186.4

Орон сууцны бус барилгын ажил 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр 348.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 133.5 (62.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд үйлдвэрийн барилгын ажил 82.7 (68.6%) тэрбум төгрөгөөр худалдаа, үйлчилгээний барилгын ажил 3.9 (13.6%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 2.2 (31.9%) тэрбум төгрөгөөр, сургууль соёлын барилгынх 19.2 (64.1%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 25.5 (86.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 7. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2023 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 532.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 60.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 7.1 нэгж хувиар өссөн байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2023 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 221.9 тэрбум төгрөг, Орхон аймагт 32.1 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 73.4 хувийг эзэлж байна. Эдгээр аймгийн нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн болон орон сууцны барилгын ажил эрчимтэй явагдаж байна.

4.3 ЭКОНОМЕТРИК ШИНЖИЛГЭЭ

“Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ-ын стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд өгөгдлийн шинжилгээ хийж санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөлөл болон хамаарлыг шинжилж, шийдвэр гаргахад ашиглах боломжийг бүрдүүлэв.

Энэхүү шинжилгээний хэсэгт “Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ-аас Борлуулалтын өртөг, Ерөнхий ба удирдлагын зардал, Нийт ашиг (алдагдал), Татварын дараах ашиг зэрэг хүчин зүйлсийг сонгосон бол макро орчны нөлөөлөл талаас Нийт хөрөнгө оруулалт, Инфляц, Ам.долларын ханш, Барилгын салбарын хөрөнгө оруулалт, Зээлийн хүүгийн түвшин, Эдийн засгийн өсөлт зэрэг хүчин зүйлсийг сонгон авлаа. Дээрх хүчин зүйлсийн хүрээнд статистикийн суурь шалгуурын шинжилгээ, тогтвортой байдлын шинжилгээ, хамаарлын шинжилгээ, хоёр болон олон хүчин зүйлсийн регрессийн шинжилгээ, Скаттер шинжилгээ, boxPlot, t шинжилгээ зэргийг хийж дүгнэлт өгсөн.


Тэдгээр дүгнэлтийг тоймлон доор харуулж, шинжилгээний ажлын дэлгэрэнгүйг хавсралтад харуулав.

Түлхүүр

Код	Тайлбар
GC	Борлуулалтын өртөг
AC	Ерөнхий ба удирдлагын зардал
TP	Нийт ашиг (алдагдал)
NP	Татварын дараах ашиг
TI	Нийт хөрөнгө оруулалт
IN	Инфляц
US	Ам.долларын ханш
CI	Барилгын салбарын хөрөнгө оруулалт
IR	Зээлийн хүүгийн түвшин
EG	Эдийн засгийн өсөлт

Дескриптив шалгуурын үр дүн

	GC	TP	AC	NP	TI	IN	US	CI	IR	EG
Skewness	-0.834	1.50	1.4969	0.619	0.2665	-0.085	0.7339	1.4368	-0.06	-0.813
Kurtosis	2.4338	3.25	3.2458	1.947	1.2563	1.451	2.5872	3.1707	1.341	2.3192
Jarque-Bera	0.6463	1.888	1.8797	0.550	0.6927	0.506	0.4843	1.7265	0.576	0.6479



Графикаас харахад борлуулалтын өртгийн тархалт зүүн хэлбийлттэй, далайц шовх, хэвийн бус тархалттай байгаа нь өртгийн төлөвлөлт эсвэл зарцуулалт бодит байдлаас зөрүү үүсдэгийг харуулж байна. Ерөнхий ба удирдлагын зардал нь инфляцаас хамааран

чанаргүйжиж байгаа ба цаг үеийн шинжтэй хөөргөдлүүд бий болдог. Нийт ашиг нэмэгдэх хандлагатай байгаа хэдий ч цаг хугацааны хувьд харилцан адилгүй, тогтвортой бус байна. Татварын дараах ашиг мөн ижил пропорциональ хамааралтай байгаа ч нийт ашигтай харьцуулахад харьцангуй тогтворжилттой байна. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх нь ашгийг өсгөх чухал хүчин зүйл болдог. Инфляцийн нөлөөлөл өндөр байгаа нь санхүүгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа ба ам.долларын ханшийн нөлөө түүнээс ч өндөр байна. Барилгын салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаагаар холбоотой өнөөгийн мөнгөний ирээдүйн үнэ цэнэ өсөх хандлагатай байна. Зээлийн хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна. Эдийн засгийн өсөлт алгуур нэмэгдэж байгаа ба энэ нь жигд өсөх боломжийг бий болгож байна.

Тогтвортой байдлын шинжилгээний үр дүн

Null: Unit root (assumes common unit root process)		
Levin, Lin & Chu t*	-8.54779	0
Null: Unit root (assumes individual unit root process)		
ADF - Fisher Chi-square	42.9248	0.0048
PP - Fisher Chi-square	36.2455	0.0286

Дээрх хүчин зүйлсийн тоон өгөгдлийн цувааны хувьд шууд ашиглахад тохиромжгүй байгаа тул нэгдүгээр эрэмбийн уламжлал авч ашиглах хэрэгтэй ба шинжилгээний үр дүнд тохируулга хийх шаардлагатай. Энэ нь хүчин зүйлс тус бүрийн хувьд болон бүлгийн хувьд адил байна.

Хамаарлын шинжилгээний үр дүн

	NR	GC	TP	AC
GC	-0.901 0.037			
TP	1.000 0.000	-0.901 0.037		
AC	1.000 0.000	-0.912 0.031	1.000 0.000	
US	0.898 0.039	-0.983 0.003	0.898 0.039	0.908 0.033
CI	0.991 0.001		0.991 0.001	0.988 0.002

Борлуулалтын өртөг нь нийт орлоготой 90%, нийт ашигтай, удирдлагын зардалтай, долларын ханштай тус тус урвуу хамааралтай байна. Ерөнхий ба удирдлагын зардал нь нийт орлого ба ашигтай шууд хамааралтай байна. Инфляц, Ам.долларын ханш, Зээлийн хүүгийн түвшин нь зардал талтай шууд хамааралтай байна. Эдийн засгийн өсөлт, Барилгын салбарын хөрөнгө оруулалт нь орлоготой шууд хамааралтай байна.

Регрессийн шинжилгээний үр дүн

Depend_Var: GC	TI	IN	US	CI	IR	EG
C	167000000	1.4	2.82	1.74	7.04	1.1
Indep_var	-23.8003	-2.62E+08	-57,243.76	-48.24698	7049748	44865328
R^2	0.175253	0.383883	0.965415	0.706731	0.165218	0.01078
Prob	0.482987	0.264996	0.002759	0.074491	0.497093	0.868043

Нийт өртөгт хамгийн гол нөлөөлөгч хүчин зүйл нь ам.долларын ханш байна. TI, IN, CI, EG зэргийн нөлөөллийг шууд тайлбарлах боломжгүй байгаа ч TI -с бусад тогтмол хүчин

зүйлсийн 1 нэгжийн өөрчлөлт нь өртгийг 167,000,000 нэмэгдүүлэх нөхцөл болдог. IN -с бусад тогтмол хүчин зүйлсийн 1 нэгжийн өөрчлөлт нь өртгийг 1.4 нэгжээр нэмэгдүүлэх нөхцөл болдог, CI -с бусад тогтмол хүчин зүйлсийн 1 нэгжийн өөрчлөлт нь өртгийг 1.7 нэгжээр нэмэгдүүлэх нөхцөл болдог, EG -с бусад тогтмол хүчин зүйлсийн 1 нэгжийн өөрчлөлт нь өртгийг 1.1 нэгжээр нэмэгдүүлэх нөхцөл болдог

Depend_Var: TP	TI	IN	US	CI	IR	EG
C	-1.33E+12	-1.98E+11	-2.83E+12	-1.13E+12	2.11E+11	1.39E+11
Independ_var	728682.1	4.64E+12	1.05E+09	1143204	-1.12E+09	1.79E+12
R^2	0.406905	0.297132	0.805858	0.982829	0.00001	0.042466
Prob	0.24687	0.342053	0.038672	0.00096	0.995919	0.739489

Нийт ашигт хамгийн гол нөлөөлөгч хүчин зүйл нь барилгын салбарын хөрөнгө оруулалт, дараа нь ам.долларын ханш байна. TI, IN, IR, EG зэргийн нөлөөлөл байгаа ч магадлалын утгаараа шууд тайлбарлах боломжгүй байна.

Depend_Var: AC	TI	IN	US	CI	IR	EG
C	3.67E+09	6.10E+09	2.29E+08	4.06E+09	7.31E+09	6.87E+09
Independ_var	1584.884	1.04E+10	2347645	2515.991	-21412013	3.61E+09
R^2	0.39459	0.305539	0.824467	0.97585	0.000774	0.035476
Prob	0.256458	0.333903	0.033031	0.001604	0.964585	0.761611

Ерөнхий удирдлагын зардалд хамгийн гол нөлөөлөгч хүчин зүйл нь барилгын салбарын хөрөнгө оруулалт, үүний дараа ам.долларын ханш байна. IN, EG зэргийн нөлөөллийг шууд тайлбарлах боломжгүй байгаа ч TI, IR -с бусад тогтмол хүчин зүйлсийн нөлөөлөл өндөр байна.

Depend_Var: NP	TI	IN	US	CI	IR	EG
C	1.69E+09	1.10E+09	1.99E+09	1.82E+09	2.56E+09	1220000000
Independ_var	-232.839	1.35E+09	-271629.6	-525.3892	-86201123	-3.69E+08
R^2	0.078007	0.046985	0.101096	0.389762	0.114884	0.003398
Prob	0.649066	0.72619	0.602094	0.260284	0.576853	0.925823

Цэвэр ашигт IN, CI, EG зэргийн нөлөөллийг шууд тайлбарлах боломжгүй байгаа ч бусад тогтмол хүчин зүйлсийн нөлөөлөл өндөр байна. TI, US, IR зэрэг хүчин зүйлс нь магадлалын хүлээн зөвшөөрөгдөх түвшнийг хангаж чадахгүй байгаа тул тайлбарлах боломжгүй байна.

4.4 НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧИН

Монгол Улсын хүн амын төрөлт, нас, хүйсийн бүтэц, дундаж насжилт, шилжилт хөдөлгөөнд тулгуурлан 2040 онд нийт хүн ам 4.61 сая болох ба үүний 2.29 сая нь эрэгтэй, 2.32 сая нь эмэгтэй хүн ам байхаар хэтийн төлөвийн тооцоолол хийсэн.

Хүн амын худалдан авах чадвар буурч, бодит орлого инфляцтай уялдаж чадахгүйгээс гадаад оронд ажиллах сонирхолтой иргэдийн тоо нэмэгдсээр байна. Энэ нь барилга, хот байгуулалтын салбарын ажиллах хүчний байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа юм. Иймд барилгын салбарт технологийг хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий болжээ.

2023 онд барилгын чиглэлээр Монгол Улсын ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуулийг нийт 1,688 оюутан мэргэжлээрээ төгсөнө гэж үзвэл энэ нь зах зээлийн нийт эрэлтийн 25 хувийг л хангах үзүүлэлт юм. 2023 оны 4-р сарын байдлаар дотоодын барилгын зах зээлд нийт 5,279 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгааг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан харвал:

Хүснэгт 7. Барилгын салбарын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны чиглэл	Аж ахуйн нэгжийн тоо	Зах зээлд эзлэх хувь
1	Зураг, төсөл боловсруулах	768	14%
2	Барилга, угсралт	4336	82%
3	Өргөх байгууламж	165	3%
4	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах	92	1%

Эх сурвалж: МБҮА ТББ-ын АА-ны БҮАТЗ-ийн хэлтэс. /Зарим компанийн үйл ажиллагааны чиглэлийн тусгай зөвшөөрөл давхардсан тоогоор орсон болно/

Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд нийгэм эдийн засгийн сөрөг нөлөө давамгайлснаас гэр хорооллыг дахин төлөвлөлтөд оролцох аж ахуйн нэгжүүдийн сонирхол буурсан байна. Түүнчлэн баригдаж буй барилгын материалын чанар, эрсдэлд тэсвэрлэх чадварын үнэлгээ нь стандарт төвшнөөс зарим тохиолдолд доогуур байгаа нь иргэдийн амь нас, эд хөрөнгөд ноцтой аюул учруулахаар байна.

Тусгай зөвшөөрөлтэй дээрх аж ахуйн нэгжүүдийн 2022 оны хүний нөөцийн эрэлтийн судалгаанаас үзвэл сантехникийн инженерийн эрэлт 95 байхад энэ жил төгсөх мэргэжилтэй хүний нөөц буюу төгсөгч байхгүй, энэ чиглэлийн мэргэжлийг сонгон суралцагчийн эрэлт байхгүйгээс 2020 онд элсэлт огт аваагүй байна. Мөн дулаан, агаар сэлгэлтийн инженерийн эрэлтэд орон тоо 110 байхад 25 төгсөгч, ус хангамжийн инженерийн эрэлт 59 байхад 16 төгсөгч ажлын байранд гарчээ. Үүнээс гадна холбоо, дохиоллын инженер чиглэлээр инженер огт бэлтгэдэггүй, мэргэжлийн анги байхгүй нь барилгын салбарын хүний нөөцийн тулгамдсан асуудал болжээ.


Дээр дурдсанаар 2023 онд төгсөх 1,688 оюутан барилгын салбарын зах зээлийн эрэлтийн зөвхөн 25 хувийг нөхөж байгаа нь Монгол Улсын барилгын салбар, дээд боловсролтой инженерийн хомсдолд орсныг харуулах бөгөөд улсын, салбарын цаашдын өсөлтийн явцад хомсдол улам нэмэгдэх нь тодорхой байна.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын судалгаагаар 2025 он гэхэд Дэлхий дахинд хотжилт 77 хувь хүртэл өсөх тул барилгын салбарын мэргэжилтнүүдийн эрэлт 27 хувиар мөн өснө гэж тооцоолжээ. Монгол Улсын хувьд 2021 оны 07-р сарын 07-ны өдөр “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд энэхүү хуульд нийслэл хот нь дагуул хоттой байхаар зааж, нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газрыг байгуулсан. Үндэсний хэмжээний төлөвлөлт /2050 он гэхэд дагуул хотуудыг байгуулж, хүн амын нягтаршлыг тархаахаар

тусгасан/ болон аж ахуйн нэгжүүдийн сул ажлын байрны тоо зэргээс үзвэл энэ чиглэлийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тоог нэмэгдүүлэх, хүүхэд залууст барилгын салбарыг сонгож, суралцах эрмэлзлийг бий болгох нь чухал болоод байна. Дээр дурдсан статистик баримтуудад дүн шинжилгээ хийвэл 2025 он гэхэд Монгол Улс барилгын салбарт сантехникийн инженер мэргэжлээр төгсөгчгүй болох бөгөөд шаардлагатай мэргэжилтэн, инженерүүдийг гадаадаас авахаас өөр аргагүй болж байна.

Үндэсний статистикийн хорооны 2023 оны 1-р улирлын тайлангаар манай улсад хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж байгаа нийт гадаадын иргэдийн 10.8 хувь буюу 519 нь барилга, үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа нь дотоодын ажиллах хүчний нөөц хангалтгүйгээс гадаадаас ажиллах хүч ажиллуулах бодит шаардлага байгаагийн илрэл юм.

Зураг 8. Барилгын салбарын хүний нөөцийн мэдээлэл



Эх сурвалж: ХНХЯ-ны дэргэдэх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. /МУ ШУТИС-ийн БАС, ЭХС-ийн хүрээнд/

“Барилга-2021” тайланд танилцуулснаар 2021 онд барилгын салбарын эдийн засагт эзлэх байр суурь дотоодын нийт бүтээгдэхүүний 3.7 хувь гэж дурджээ. 2022 оны 6-р сарын 08-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын дугаар 231 тогтоолоор Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд дотоодоос хангах боломжгүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлэх, Ковид-19 цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд гадаадаас авах ажиллах хүчийг квотгүй болгосон. Үүнээс өмнө барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн нийт ажилтны тооноос хамааруулж 10-60 тооны гадаад мэргэжилтэн ажиллуулах квоттой байсан ба 2022 онд дугаар 231 тогтоол гарснаар Засгийн газрын 2021 оны 339-р тогтоолыг цуцалсан.

Цаашид барилгын салбарт гадаадаас авах ажиллах хүчийг квотгүй хэвээр нь үлдээж, барилгын салбарын хөгжлийг дэмжих чиглэлд Засгийн газар, яамдын зүгээс гадаадын ажиллах хүчний татварын хэмжээнд хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлж, эдийн засгийн өсөлтөд уг салбарын оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна. Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсыг хөгжүүлэх шаардлагатай дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл” болон “Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийг чиглэл”-ийг 2023 оны 03 сарын 29-ны өдөр 115 тоот тогтоолоор баталсан. Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэлд барилгын инженерчлэл, цахилгааны инженер, электроникийн инженерчлэл, барилгын материалын

үйлдвэрлэлийн технологи, барилгын бүтээц эдлэлийн технологи, хот ба бүс нутгийн төлөвлөлт, архитектор зэрэг мэргэжлүүд орсон нь төрөөс барилгын салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүтэй байдлыг арилгахад анхаарч буй сайшаалтай алхам болсон.

Эдгээр ажлыг цаашид бодлогын түвшинд авч хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, мэргэжилтэн бэлтгэж буй мэргэжлийн их дээд сургуулийн хамтын ажиллагаа чухал. Мэргэжилтэй боловсон хүчин, дээд боловсролтой барилгын салбарын мэргэжилтнүүдийн эрэлт их байгаа ч нийлүүлэлт хангалтгүй байдлыг тэнцвэржүүлэхэд төрийн бодлогын баримт бичгийн хүрээнд хууль, эрх зүйн орчныг сайжруулах, аж ахуйн нэгжүүдийн ажлын үнэлгээг олон улсын жишигт нийцүүлэх, зах зээл, олон улсад өрсөлдөхүйц цалин хөлсний системийг бий болгох, салбарын зохицуулалтын баримт бичгийг нарийвчлах, боловсролын салбарын хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг хүрээнд сайжруулах бодит боломж бий.

4.5 БАРИЛГЫН САЛБАРЫН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Өнөө үед робот, хиймэл оюун ухаан, блокчейн, нанотехнологи, квант компьютер, биотехнологи, зүйлсийн интернэт, 3D принтер, автомат жолоодлого гэх мэт "Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал" -ын төрөл бүрийн дэвшилтэт технологиудыг ашигласнаар барилга, бүтээн байгуулалтын салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дэлхий даяар анхаарлаа хандуулж байна.

Барилгын технологи нь компаниудад маш их давуу талыг бий болгож, байнга хөгжин өөрчлөгдөж буй зах зээлд өрсөлдөх чадвартай байхын тулд хамгийн сүүлийн үеийн технологийн чиг хандлага, инновацыг нэвтрүүлсээр байна. Сүүлийн үеийн технологийг нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бол хамгийн түрүүнд барилгын технологийн шинэ чиг хандлагуудыг тооцон үзэх нь чухал юм. Учир нь эдгээр алхмууд нь эцсийн шийдвэр гаргах удирдлагуудад тухайн шилжилтийн явцад ямар нэгэн асуудалгүй, илүү үр дүнтэйгээр өөрчлөлтөд дасан зохицоход туслах юм. Барилгын салбарт дараах технологийн өөрчлөлт гарч байна. Эдгээр нь:

- *Барилгын мэдээллийн загварчлал:* Энэ бол барилгын орчин нөхцөл дэх биет цэгүүдийн виртуал дүрслэлийг бий болгох түгээмэл арга техник юм. Энэ төрлийн загварчлал нь төслүүдийн бүтээн байгуулах явцад илүү сайн харилцан үйлчлэлийг авчирдаг. Энэхүү тренд нь ирээдүйд төлөвлөж буй ажлууд болон нарийвчилсан зургийг зөвөөр ойлгоход тус болно. Барилгын мэдээллийн загварчлалын систем нь орон сууц болон худалдааны талбай (3D, 4D, 5D, тэр ч байтугай 6D хэмжээст) зэрэг төрөл бүрийн загваруудыг гаргах боломжтой. Тренд болж буй энэ технологи нь барилгын салбарт хэрэглэгдэж буй хамгийн сүүлийн үеийн дрон гэх зэрэг хэрэгслийг ашиглан барилгын дижитал хувилбаруудыг бүтээх бодит багаж хэрэгсэл болж байна.
- *Барилгын өртөг тооцооллын программ:* Барилгын төслийн нэг бодит үзүүлэлт нь тухайн төслийн санхүү тооцоолол юм. Хөтөлбөр, зардал, үнийн санал зэргийг тооцоолдог дижитал технологи нь төслийн цаг хугацаа, нөөцийг хэмнэж, үр дүнд нь илүү бүтээмж, ашиг олоход тусалдаг. Гар аргаар цаасан материал болон энгийн хүнд суурилсан тооцоолол хийх нь уламжлалт тооцооллын аргачлал юм. Программ хэрэглээг тооцоолох нэг давуу тал нь тэрхүү дата өгөгдлийг шууд хэрэглэгч рүү илгээх чадвар юм. Мөн түүнчлэн төслийн тендер чанартай, сайтар боловсруулсан бол үйлчлүүлэгч гарын үсэг зурах өндөр магадлалтай юм.
- *Хиймэл оюун ухаан:* Барилгын төслүүд нь өгөгдлийг илүү хурдан бөгөөд үнэн зөв боловсруулахад зориулж хиймэл оюун ухааны шийдлүүд (хүний оюун ухааны үйл явцыг машинуудаар загварчлах) шаардах асар их хэмжээний мэдээллийг агуулдаг. Төсөл хэрэгжүүлэх хугацаанд цуглуулсан өгөгдөл мэдээллийг ашиглан хиймэл оюун ухааны Machine learning, hine learning буюу машинд суралцах процессоор ирээдүйд гарах боломжтой төслийн боломжит үр дүнг урьдчилан таамаглах юм. Хиймэл оюун ухаан нь барилга барьж буй робот болон ажлын үйл явцыг хянах зориулалттай дронтой холбогдож ажлын талбарын бүтээмжийг сайжруулахад ашиглах боломжтой.
- *Робот болон нисгэгчгүй онгоц (дрон):* Робот болон дрон хэзээ ч ажилтнуудыг орлохгүй. Тэд зүгээр л хүмүүсийн ажилд тусалж, гүйцэлдүүлдэг. Робот техник, дрон ашиглах нь барилгын үйл явц, ялангуяа ажилчдын аюулгүй байдлыг хангах олон давуу талтай. Дрон нь ажилчдын цаг хугацаа, хөрөнгө мөнгийг хэмнэхэд тохиромжтой. Орчин үеийн машинууд нь ажлын процессууд болон бусад бүхий л ажилтай холбоотой зүйлсийн аюулгүй байдлыг шалгаж чадна. Тэд мөн болзошгүй бэрхшээлийг илрүүлж чадах бөгөөд хүний оролцоогүйгээр ажлын талбай дээрх олон ажлыг гүйцэтгэх

чадамжтай. Барилгын салбарын ихэнх робот, дронуудад ашиглах боломжтой алсын удирдлага нь ажилчдад ажлын талбай дээр дээрх төхөөрөмжүүдийн чиглэлийг хянах, өөрчлөх боломжийг олгодог. Орчин үеийн роботуудын ачаар хүнгүй ажиллах горим нь бэртэл гэмтэл болон бусад аюултай нөхцөл байдлын бараг тэг хувийн магадлал бүхий аюулгүй барилгын орчныг бий болгож байна.

- *Аюулгүй байдлыг хангах технологи* : Барилгын салбарт аюулгүй байдлыг урьдчилан таниулах, анхааруулга өгөх, эрсдэлийг бууруулах олон технологиуд нэвтрэн бий болсоор байна. Сүүлийн үеийн технологиуд улам бүр аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн. Тухайлбал, WIFI төхөөрөмжтэй холбогддог ажлын гутал нь тухайн хүнийг унахаас сэргийлэн анхааруулах дохио өгдөг ба тоосго өрөх зориулалттай роботууд ч мөн бий болсон. Хиймэл оюун ухаан асар их үүрэг гүйцэтгэдэг бөгөөд роботууд ч хүмүүсийн хийдэг үйлдлүүдийг гүйцэтгэх боломжтой болж хүмүүсийн шийдвэр гаргах чадамжуудыг улам нэмэгдүүлж байна. Мөн ямарваа нэгэн барилгын талбайн дуу чимээ, дулаан, салхи зэрэг хүрээлэн буй орчны аюулыг таних, ажилчдад урьдчилан анхааруулах байгаль орчны мэдрэгч зэргийг ашиглах боломжтой болжээ.
- *Модульчлагдсан барилга байгууламж ба технологи*: Олон жилийн турш модульчлагдсан болон угсармал барилгын технологи нь байсаар ирсэн ба 2022 онд олон бүтээн байгуулагчид, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдийн дунд эрэлт хэрэгцээ нь илүү нэмэгдсэн. Мэргэжлийн ажиллах хүчний хомсдол, зардал хэмнэх, техник технологи нэмэгдсэнтэй холбоотойгоор 2025 он гэхэд модульчлагдсан барилга зах зээлд 110 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Модульчлагдсан барилга нь уламжлалт барилгын арга барилгыг шинэ алхамд шилжүүлэх боломжуудыг олгож байгаа бөгөөд үйлдвэрлэлийн хэв маяг руу түлхүү чиглүүлж байна. Дижитал хувиргалт ба дижитал хэрэгслийн дэвшил нь модульчлагдсан барилгын хурдасгуур байж магадгүй юм.
- *CAD болон BIM технологи*: BIM буюу барилгын мэдээлэл солилцох загварчлал нь барилгын салбарын бүхий л архитекторууд, инженерүүд, гүйцэтгэгчид зэрэг хамтран ажиллагч нар нэгдэн нэг дор барилгын зураг төсөл, бүтээн байгуулалт, ашиглалтын тал дээр хамтран ажиллах боломжийг олгож байгаа ухаалаг программ хангамж юм. Энэ нь тэдний бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна цаг хугацаа болон асар их зардлыг хэмнэдэг. Тиймээс BIM нь яах аргагүй барилгын салбарын мэргэжилтнүүдийг ашигладаг хамгийн сүүлийн үеийн шилдэг технологиудын нэг юм. Харин CAD (компьютерын тусламжтайгаар дизайн бүтээх)- ийн тусламжтайгаар барилгын загварын бүтэц зохион байгуулалтыг нэг бүрчлэн гаргах боломжтой. CAD нь мөн сүүлийн үед тренд болсон хэвээр байна.
- *Нарийн төлөвлөгдсөн арга хэрэгсэл*: Сүүлийн жилүүдэд барилгын мэргэжилтнүүдийн дунд энэхүү арга хэрэгсэл нь ихээхэн байр суурийг эзэлж байна. Барилгын салбарын бүхий л мэргэжилтнүүд нэгдсэн зохион байгуулалтад орж барилгын зураг төслөөс эхлээд цаашид гаргах хог хаягдлыг бууруулах зэрэг барилга баригдах бүхий л үе шатуудыг нарийн тооцоолон гаргах нь найдвартай байдал болон урьдчилан таамаглах боломжийг тэдэнд олгодог аж. Энэ нь эргээд хэрэглэгчдэд хүрэх үнэ цэнийг улам илүү нэмэгдүүлдэг байна.
- *Хүний нөөцийн технологи*: Барилгын компаниудын хүний нөөцийн мэргэжилтнүүдийн ажлын байрыг хэвээр хадгалах, мэргэшсэн чадвартай ажилчдыг эрэлхийлж байна. Sage AGC-ийн тайланд барилгын компаниудын 54 хувьд нь ажлын байран дээр мэргэшсэн ажилчдыг олоход хүндрэл бэрхшээлтэй байдаг гэжээ. Гэрэлт цамхаг

төвийн судалгаа, зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн Бен Юбанкс хэлэхдээ “Барилгын фермүүд энэхүү асуудлаа шийдэхийн тулд хүний нөөцийг оруулах боломжтой шинэлэг техник технологиудыг хайж байна” гэв.

- *Ажлын талбайд ашиглагдах гар утасны программууд:* Гар утасны аппликейшны тусламжтайгаар ажилчдын цагийн бүртгэл, гүйцэтгэл, хариуцлага тооцох, утасны камераар хэмжилт хийх зэрэг олон үйлдлүүдийг шуурхай гүйцэтгэх боломжтой. Учир нь “COVID-19” цар тахлын үед алсын уулзалт хийх зэргээр гар утасны зарим нэг аппликейшны хэрэгцээ улам нэмэгдсэн. АЕСОМ зэрэг компаниуд олон нийтийн төслүүдэд зориулсан виртуал уулзалтуудыг бий болгох технологийг хөгжүүлсэн бөгөөд AirMeasure, Infotycoon зэрэг бусад программууд одоо ч алдартай хэвээр байна.
- *Барилгын менежментийн программ хангамж:* Барилгын менежментийн программ хангамж нь өрсөлдөх чадварыг улам нэмэгдүүлэх, бизнесийн үр ашигтай байдал болон үнэ цэнийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Барилгын менежментийн тэргүүлэгч программ хангамж нь өгөгдөл эмхэтгэх, гар утсаар хоорондоо файл хуваалцах, төсөв зохиох, баримт бичиг хадгалах, цалин хөлс, хүний нөөцийн болон бараа материалын хяналт зэрэг бүх талын хэрэгцээг хамардаг.
- *Ухаалаг хотууд:* Дэлхийн хамгийн том технологийн компаниуд ухаалаг, тогтвортой хотуудад их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Олон улсын ухаалаг хотуудын өсөлт 2025 он гэхэд 20.5%-иар өсөж, 2.5 их наяд ам.долларт хүрнэ. Дэлхийн ухаалаг хотуудын томоохон төслүүдийг дараах хотууд эзэлж байна. Үүнд Арабын Нэгдсэн Эмират улсын Масдар сити, Өмнөд Солонгосын Сонгдо олон улсын бизнесийн дүүрэг, Нью-Йорк хотын Хадсон үйлдвэрийн коридор зэрэг орнуудын хотууд багтаж байна. Ярдс, Энэтхэгийн Дели-Мумбай аж. Барилгын салбарын мэдээлэл технологийн чиг хандлага нь “Контех” буюу барилгын салбарын технологи болон технологийн загварчлалын дэвшилт, дрон хөгжүүлэлт зэрэг олон хөгжүүлэлтээс эхлээд нэгэн шинэ хэлбэр лүү шилжин орж байна. Барилгын салбарын дижитал өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд гол оролцогч талууд хамтран зөв шийдлийг олох шаардлагатай болжээ.

4.6 ХУУЛЬ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Барилга, хот байгуулалтын салбарын үйл ажиллагаанд 33 хууль, УИХ-ын 8 тогтоол, ЗГ-ын 32 тогтоол, Сайдын 74 тушаал, ТНБД-ын 3 тушаал мөрдөж байна³. Эдгээрийг хэрэгжүүлэх норм, норматив, дүрэм журам, технологи, стандартыг зайлшгүй шинэчлэн сайжруулах шаардлага тулгамдаж байна.

Хүснэгт 8. Хууль эрх зүйн орчны шинжилгээ

№	БАРИМТ БИЧИГ	ХУУЛЬ	ДҮРЭМ, ТОГТООЛ, ЗААВАРЧИЛГАА
1	Барилга, бүтээн байгуулалт	1. Барилгын тухай хууль 2. Хот байгуулалтын тухай 3. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай 4. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай 5. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай 6. Орон сууцны тухай 7. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай 8. Орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай	1. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо батлах тухай 2. Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам 3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм 4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам 5. Барилгын ажлын захиалагчийн дүрэм 6. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм 7. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм 8. Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм 9. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм 10. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм 11. Барилга захиалагчийн дүрэм 12. Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай 13. Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого 14. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам 15. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм 16. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм 17. Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого 18. “барилга байгууламжийн галын аюулгүй байдал” /бнбд 21-01-02/ 19. Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах. Бнбд 21-01-02. 20. Барилга байгууламжийн галын аюулгүй байдал. 21. Галын аюулгүй байдлын норм бнбд 21-02-02 22. Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал бнбд 21-01-024/18/16 23. Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам 24. Барилга байгууламжийн түвэгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм 25. Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм

³ <https://mcud.gov.mn/ld> - Барилга Хот Байгуулалтын Яам

			26. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам 27. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам 28. Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм 29. Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам 30. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам 31. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм
2	Хяналт аудит	1. Аудитын тухай хууль 2. Хяналт шалгалтын тухай хууль 3. Мэргэжлийн хяналтын тухай хууль 4. Архивын тухай 5. Байгууллагын нууцын тухай 6. Галын аюулгүй байдлын тухай 7. Гамшгаас хамгаалах тухай 8. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай 9. Нийгмийн даатгалын тухай 10. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай 11. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 12. Нягтлан бодох бүртгэлийн тухай 13. Статистикийн тухай 14. Татварын ерөнхий хууль 15. Төрийн албаны тухай 16. Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 17. Төрийн аудитын тухай 18. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 19. Төрийн хяналт шалгалтын тухай 20. Төсвийн тогтвортой байдлын тухай 21. Төсвийн тухай 22. Улсын бүртгэлийн ерөнхий хууль 23. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай 24. Усны тухай 25. Хөдөлмөрийн тухай 26. Хувь хүний орлогын албан татварын тухай 27. Шилэн дансны тухай 28. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 29. Байгууллагын нууцын тухай 30. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 31. Орлогын албан татварын тухай хууль 32. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татварын тухай	1. Хяналт шинжилгээ үнэлгээний журам 2. Аудитын горим 3. Санхүүгийн тайлангийн аудитын журам 4. Стандарт ажиллагааны горим 5. Дотоод аудитын дүрэм 6. Аудитын олон улсын стандартууд 7. Шалгалт авах журам 8. Дотоод аудитын дүрэм 9. Дотоод албан томилолтын тариф 10. Дотоод хяналтын журам 11. Дотоод албан томилолтын журам 12. Чанарын гадаад хяналт журам 13. Лабораторийн гадаад хяналтын журам 14. Стандарт технологийн журам 15. Технологийн горим

		33. Засгийн газрын тусгай сангийн тухай 34. Инновацын тухай 35. Иргэний хууль 36. Монгол улсын үндсэн хууль 37. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс 38. Урьдчилан сэргийлэх тухай 39. Төсвийн тухай 40. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай 41. Харилцаа холбооны тухай 42. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 43. Хөдөлмөрийн тухай 44. Хөрөнгө оруулалтын тухай 45. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай 46. Цахим гарын үсгийн тухай 47. Шилэн дансны тухай	
--	--	---	--

4.7 БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН НӨЛӨӨ

Хүн ам суурьших нутаг дэвсгэрийн боломжит даацын үнэлгээг аймгуудаар шинэчлэн гаргасан бөгөөд мөн усны нөөц ашиглалтын хэтийн төлөвийн хувьд Улаанбаатар хотын усны нөөц хангамжид 2038 онд хомсдол үүсэх эрсдэл байгаа болон говийн бүсийн Ханбогд, Цогтцэций суурьшлын бүсүүдийн хотжилт, Тавантолгой дулааны цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэр, зэс хайлуулах үйлдвэр, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор, төмөр зам, авто замын тээвэр логистикийн хөгжлийн хандлагатай уялдаад одоогийн хангаж байгаа гүний усны нөөц нь хангалтгүй байгааг харгалзаж, Орхон-Говь, Хэрлэн-Говь төслийг боловсруулж хэрэгжүүлэн гадаргын ус дамжуулах хоолойгоор говийн бүсийг хангах нь тогтвортой хөгжлийн бодлогод нийцэж байна. Хүн амын өсөлтийн хэтийн тооцоог нэгдсэн байдлаар аймаг, хот, сум бүрээр 2040 он хүртэл таамаглаж гаргасан бөгөөд түүнд тулгуурлан хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүдийг боловсруулснаар өмнө нь хүн амын өсөлтийг хэт өндөр тооцоололтойгоор өндөр хүчин чадалтай төлөвлөгдөж байсан асуудлыг цэгцэлж, хөрөнгө оруулалтын орон зайн оновчтой төлөвлөлтийг бий болгох боломжтой болж байна. Мөн хөрөнгө оруулалтаар баригдаж буй нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламжууд болон хүн амзүйн мэдээллийн нарийвчилсан нэгдсэн сантай болсноор орон зай, ач холбогдлын эрэмбээр нэгдсэн жагсаалтаар гарч, хөгжлийн хөрөнгө оруулалтын үр ашиг дээшилнэ.

ХАНСХЕТ-ийн гол зорилго нь 2040 онд 4.5 сая болж өсөх, Монгол Улсын хүн амыг оршин суугаа газар бүртээ эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд тогтвортой суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөлийг хангах, хүн амын суурьшил, хот байгуулалтын орон зайн оновчтой төлөвлөлтийг бий болгох юм. Төлөвлөлтийн шийдлийн хүрээнд хотуудын зэрэглэл, ангилал, засаг захиргааны статусыг оновчтой тодорхойлно. Нутаг дэвсгэрийн орон зайн төлөвлөлтийн хүрээнд бүлэг суурины төвүүд, зам тээврийн босоо болон хэвтээ үндсэн, дэд тэнхлэгүүдийг тогтоож, нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах үүднээс шилжилт хөдөлгөөнийг татах хүчин зүйлсийг дагуул болон хоёрдогч хотуудад оновчтой байршуулах саналыг боловсруулна.

Монгол Улсын хэмжээнд хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны хувьд 90 бүлэг суурины тогтолцоотой байхаар саналаа боловсруулаад байна.⁴



⁴ <https://barilga.gov.mn/> 2023.06.28

БҮЛЭГ 5. БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-ЫН ДОТООД НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын дотоод орчны нөхцөл байдлын судалгааг системийн дотоод бүрдүүлэгч хүчин зүйлс буюу менежментийн чадамж, процессын шинжилгээний хүрээнд авч үзлээ.

5.1 МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАМЖИЙН СУДАЛГАА

Байгууллагын менежментийн чадамж гэдгийг “байгууллагын зорилгод хүрэхийн тулд нийгмийн тодорхой эрэлтийг хангах үйлдвэрлэл, үйл ажиллагааг эрхлэх явцад нөөц чадавхыг бүрэн дүүрэн дайчилж, өндөр бүтээмжтэй ажиллах ажилтнуудын ур чадварын нэгдэл бөгөөд тухайн үйлдвэрлэлийн гарцын чанартай, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны цогц” гэж тодорхойлж байна. Энэ нь удирдлагын шийдвэр, ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх мэдлэг, гүйцэтгэлийг хангах ур чадвар, авьяас, сэтгэл зүтгэл, хандлагын цогц нэгдэл болох нь харагдаж байна. Менежментийн чадамжийг тодорхойлох эхэн үеийн асуудал нь ердөө удирдлагын чадамжийг хэрхэн тодорхойлох вэ гэсэн асуултад хариулах явдал байжээ.

Зарим судлаачид менежментийн чадамжийг тодорхойлохдоо ажлын байран дээрх чадвар, мэдлэг, ажлын гүйцэтгэлийн үр дүн гэжээ. Шинэ Зеландын Удирдлагын Институтийн шийдвэрлэснээр менежментийн чадамж нь бизнес болоод байгууллагын гүйцэтгэлийг харуулах бөгөөд удирдлагын үйл ажиллагааны үр дүнд байгууллагын үйл ажиллагааны хөгжил, цар хүрээг тодорхойлогч байх юм. Менежментийн чадамжийн хэмжүүр нь ингэхлээр удирдлагын үр дүн, гүйцэтгэлийг хангах ур чадвар, авьяастай холбоотой нь харагдаж байна. Менежментийн чадамжийн индекс нь менежментийн гүйцэтгэлийн үнэлгээг оноогоор харуулдаг. Ингэснээр компанийн дээд удирдах албан тушаалтан, менежер, байгууллага, бүлэг, салбар төдийгүй аль нэгэн улс орон тэдгээр шалгуураар өөрийгөө үнэлж, менежментийн хувьд хэр чадамжтай байгаа болон аль эсвэл шаардлага хангахгүй байгаа тухайгаа олж харах боломж бүрддэг. Ийм учраас Менежментийн чадамжийн индексийг компанийн дээд удирдлагууд, аливаа байгууллага, салбар, тэр бүү хэл бүхэл бүтэн улс орнууд хүрсэн түвшнийг өөрсдөө бодитойгоор үнэлж, өөр хоорондоо жишиж харьцуулах аятай боломжийг олгодог онцгой ач холбогдолтой юм.

Хамт олны менежментийн нөхцөл байдалд шинжилгээ хийж стратегийн бэлэн байдлыг тодорхойлоход судалгааны ажлын зорилго оршино.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Тухайн байгууллагын нэгж, хэсэг, оролцогч бүлгүүд өмнөө тавьсан тодорхой зорилго, зорилт, бодлогоо тодорхойлсон байдлыг хүлээн авах ажилчдын хандлага
- Хүний нөөцийг төлөвлөж, хүмүүсийг манлайлан идэвхжүүлж, урамшуулж, мэдлэг чадварыг нь хөгжүүлж, нээлттэй байдал бий болгосноор хүрэх үр дүн
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг ямар хамааралтай байгааг шинжлэх болон стратегийн төлөвлөгөөнд тусгах арга замыг тодорхойлох
- Байгууллагын зан үйл, соёл болон хамтын ажиллагааны үр шим, талууд хоорондын харилцан ашигтай харилцааг судалж, стратеги төлөвлөгөөнд тусгах;
- Байгууллагын нөөцийн ашиглалт, чадавхын байдалд үнэлгээ өгөх;
- Байгууллага дахь мэдээллийг мэдлэг, мэдлэгийг чадвар болгож хувиргах чадамжийг судалж, стратегийн төлөвлөгөөнд тусгах
- Судалгааны үр дүнд тулгуурлан санал, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Судалгааны үр дүнг Удирдлагын академийн бизнесийн болон төрийн байгууллагуудын стратегийн бэлэн байдлыг” тодорхойлсон судалгааны аргачлал, гадаад орны зарим туршлагыг иш үндэс болгон 5 бүлэг, 20 шалгуур үзүүлэлтээр /индикатор/ тодорхойлсон. Судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулалт, шинжилгээ хийхэд тоон аргуудыг ашигласан. Тоон судалгааны мэдээллийг урьдчилан боловсруулж, асуулгаар цуглуулсан ба мэдээллийг Microsoft Excel 2023 зэрэг программыг ашиглан боловсруулалтыг хийсэн. Нийт 96 саналаас авч судалгаанд оролцсон.

Судалгааны энэхүү бүлэгт байгууллагын удирдлага зохион байгуулалтын талаарх ажилчдын үзэл бодол, санал хүсэлтийг тодорхойлох, стратеги төлөвлөгөөнд анхаарч авч үзэх зарим асуудлыг тодорхойлох юм. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ 2023-2028 оны хөгжлийн үзэл баримтлал, 2022-2027 он хүртэл дунд хугацааны төлөвлөгөө боловсруулахад ажилчдын үзэл бодлыг тусгах зорилгоор авсан стратегийн бэлэн байдлын судалгаанд нийт 96 хүн оролцсон байна.

Хүснэгт 9. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын чадамжийн үзүүлэлтүүд


№	ЧАДАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ҮНЭЛГЭЭ
1	Зорилго, зорилт	81.60 Маш сайн (-)
2	Манлайлах ур чадвар	82.00 Маш сайн (-)
3	Бүтэц, зохион байгуулалт	75.02 Сайн
4	Идэвхжүүлэлт, хөшүүрэг	77.06 Сайн
5	Харилцаа, хамтын ажиллагаа	72.00 Сайн
6	Зан үйл, соёл	73.90 Сайн
7	Нөөцийн ашиглалт, чадавх	70.04 Сайн (-)
8	Мэдлэг инновац	75.18 Сайн
9	Бүтээмж, чанар, гүйцэтгэл	74.88 Сайн
	НИЙТ	75.74 Сайн

Хүснэгтээс үзвэл, судалгааны хүрээнд шинэчилсэн стратегийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхдээ чадамжийн хүчин зүйлсийг зайлшгүй тусгаж хэрэгжүүлэх нь ажилчид, удирдлагууд урам зоригтой хамтран ажиллах, ажлын гүйцэтгэл сайжрах, сонирхол, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зарим чухал үндэслэл болно. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ нийт дунджаар 75.74% Сайн чадамжтайгаар үнэлэгдсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү)

5.2 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН СТРАТЕГИЙН БЭЛЭН БАЙДЛЫН СУДАЛГАА


Судалгааны энэхүү бүлэгт байгууллагын удирдлага зохион байгуулалтын талаарх ажилчдын үзэл бодол, санал хүсэлтийг тодорхойлох, стратеги төлөвлөгөөнд анхаарч авч үзэх зарим асуудлыг тодорхойлох юм. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ 2023-2028 оны хөгжлийн үзэл баримтлал, 2022-2027 он хүртэл дунд хугацааны төлөвлөгөө боловсруулахад ажилчдын үзэл бодлыг тусгах зорилгоор авсан стратегийн бэлэн байдлын судалгаанд нийт 96 хүн оролцсон байна.

Зураг 9. Та бүхэн өөрийн байгууллагын одоогийн бүтэц, зохион байгуулалтыг хэрхэн дүгнэж байна вэ?




Байгууллагын бүтэц зохион байгуулалт оновчтой эсэхэд судалгаанд оролцогчид зарим нэг чиг үүргийг тодорхой болгох 50%, оновчтой 44,4%, оновчтой бус 0%, мэдэхгүй 5.6% өгсөн байгаа нь энэ тал дээр ажлын байгууллагын стратеги болон дотоод орчны төлөвлөгөөнд үндэслэн бүтцээ дахин сайжруулах хэрэгтэй нь харагдаж байна.

Зураг 10. Та байгууллагын нэгж хэсгүүдийн үйл ажиллагааг уялдаа холбоо сайтай гэж дүгнэх үү?




Байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо сайтай байдал тийм 66.7%, үгүй 16.7%, мэдэхгүй 16.7% гэж тус тус хариулжээ. Бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг уялдуулах ажлыг стратеги төлөвлөгөөний нэг хэсэг болгох шаардлагатай харагдаж байна.

Зураг 11. Байгууллагын стратеги үйл ажиллагаа аль чиглэлээр түлхүү хөгжих ёстой вэ?




Байгууллагын стратеги үйл ажиллагаа аль чиглэлээр түлхүү хөгжих ёстой гэж та үзэж байна вэ? гэсэн асуултад барилгын салбарын бизнесийн орчныг сайжруулах 58.80%, салбар болон хэлтсүүдийг хөгжүүлэх 29.40%, бодлогын судалгааны байгууллага болж хөгжих 11.80% тус тус хэрэгтэй гэж үзжээ.

Зураг 12. Үр дүн, гүйцэтгэлийн чанар ямар хэмжээнд байна гэж Та дүгнэж байна вэ?




Үр дүн гүйцэтгэлийн чанар маш сайн 11.1%, сайн 61.1%, дунд зэрэг 27.8% бусад нь муу болон мэдэхгүй гэж тус тус үзсэн байна.

Зураг 13. Үр дүн, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхийн тулд бид юунд анхаарлаа хандуулах ёстой гэж үзэж байна вэ?



Үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ? гэдэг үнэлгээнд үйл ажиллагаа үйл явцыг сайжруулах 11.1%, ажлын орчин сайжруулах 18.5%, мэдээллийн үйл ажиллагаа 12,90%, удирдлагын үйл ажиллагаа 5.950%, ажилтнуудын мэдлэг боловсрол 20.36% нэгж хэсгүүдийн уялдаа холбоог сайжруулах 7.40%, ажилтнуудын дэмжлэг туслалцаа 3.70% тус тус дэмжжээ. Үүнээс ажилтнуудын мэдлэг боловсрол, үйл ажиллагаа, үйл явц болон ажлын орчин сайжруулах хамгийн өндөр хувьтай байна.


Зураг 14. Байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэхэд юунд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж Та үзэж байна вэ?




Байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэхдээ ажлын алба, ажилтнуудын оролцоог дэмжих, ажлаар хангах 18.53%, ажилтнуудын чадавхыг сайжруулах 24.06%, үйл ажиллагааг ил тод болгох 1.92%, бизнесийн төв байгуулах 1.22%, маркетингийг хөгжүүлэх 0.17% олон улсын түвшинд ажиллах гэж тус тус үзжээ. Эдгээр асуудлууд нь жигд байдлаар тодорхойлогдсон байгаа бол хамгийн өндөр үнэлгээгээр ажилтнуудын чадавхыг сайжруулах гэж үзсэн байна. Тиймээс байгууллагын үйл ажиллагааг сайжруулахдаа эдгээр асуудлууд дээр анхаарах шаардлагатайг харуулж байна. Мөн нэмэлтээр:

- Нийт ажилтнууддаа хувь хүний хөгжил, багаар ажиллах, алсын хараатай байх, сайн ярилцаж ойлголцох тал дээр анхаарч ажилламаар байна.
- Байгууллагын хөгжлийг харж удаан ажиллах хэмээн ажилчид санал өгсөн байна.

Зураг 15. Та байгууллагадаа ажиллаж байгаадаа сэтгэл хангалуун байж чаддаг уу?




Зураг 16. Ажлын албаны хувьд хөдөлмөрийн бүтээмж ямар түвшинд байна гэж Та үзэж байна вэ?




Хөдөлмөрийн бүтээмж өндөр 61.10%, дунд зэрэг 38.90%, сул 0%, мэдэхгүй 0% гэж тус тус үзжээ. Үүнээс харвал ажилчид хөдөлмөрийн бүтээмж сайн ажилладаг гэж үзэж байна.

Зураг 17. Байгууллагаас дэвшүүлж буй зорилго, зорилтууд Таны хүлээлт, сонирхол, хэрэгцээ, шаардлагатай нийцдэг үү?




Байгууллагаас дэвшүүлж буй зорилго, зорилтууд ажилчдын хүлээлтэд нийцэж буй байдлыг авч үзвэл тийм 61.1%, зарим тохиолдолд 38,9%, үгүй 0%, мэдэхгүй 0% гэж тус тус хариулсан байна.

Зураг 18. Байгууллагын санхүүгийн чадварыг дээшлүүлэхийн тулд удирдлагын зүгээс юу хийх ёстой гэж Та үзэж байна вэ?




Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахдаа санхүүгийн ил тод байдлыг бий болгох 22.2%, зардлыг бууруулах 5.6%, үйл ажиллагааны тоо, хэмжээг нэмэгдүүлэх 16.7%, үйлчилгээний цар хүрээ, тоог нэмэгдүүлэх 55.6%, бусад 0% гэж тус тус санал өгсөн нь санхүүгийн үйл ажиллагаандаа эдгээр зүйлийг нарийвчлалтайгаар тусгаж хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

Зураг 19. Нэгдсэн программыг ашиглаж, нээлттэй тайлагнаснаар хамт олны идэвх, санаачилга дээшилнэ гэж Та үзэж байна уу?




Байгууллага нь мэдээлэл, шинжилгээний нэгдсэн программыг ашиглаж, нээлттэй тайлагнаснаар хамт олны идэвх, санаачилга дээшилнэ гэж үзэж байгаа ажилчдын 72.2%, эргэх холбоотой ажиллах нь 11.1% үзсэн бол энэ үйл ажиллагаа уялдаагүй, шаардлагагүй гэж нийт ажилчдын 16.7% үзжээ.

Зураг 20. Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн худалдан авалт, хүрэлцээ хангамж, хэрэглээ ашиглалт хангалттай гэж Та дүгнэх үү?




Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн худалдан авалт, хүрэлцээ, хангамж, хэрэглээ, ашиглалт хангалттай байгааг авч үзэхдээ хангалттай 27.6%, дунд зэрэг 66.7%, хангалтгүй 5.6% гэж тус тус үзэж байгаа нь нийт ажилчдын хувьд хангалтгүй, дунд зэрэг гэж үзэж байна.

Зураг 21. Ажилтнуудын нийгмийн хангамж, урамшуулал идэвхжүүлэлт ямар түвшинд байна гэж Та үздэг вэ?



Нийгмийн хангамж, урамшуулал, идэвхжүүлэлт хангалттай 33.3%, дунд зэрэг 55.6%, хангалтгүй 11.1% гэж тус тус хариулсан байна. Үүнээс харвал 66% нь хангалтгүй, дунд зэрэг гэж үзсэн нь ажилтнуудын нийгмийн хангамж, урамшуулал, идэвхжүүлэлтийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Зураг 22. Таны хувьд урамшуулал идэвхжүүлэлтийн ямар хэлбэрийг илүүд үзэх вэ?



Урамшууллын арга, хэлбэрүүдийг авч үзвэл хамгийн өндөр хувьтай нь цалингийн нэмэгдэл 38.9%, байр, орон сууцтай болох 27.8%, ахуйн хэрэглээний нөхцөлөө сайжруулах 5.6%, автомашинтай 5.6%, ажлын үр дүнг шударгаар үнэлэх 17.7%, аяллын урамшуулал 5.6% гэж тус тус хариулжээ. Урамшууллын тогтолцоог сайжруулж цалингийн нэмэгдэл, байр, орон сууцтай болох урамшууллыг бий болгох шаардлагатай нь харагдаж байна.


БҮЛЭГ 6. НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН

6.1 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ГАДААД, ДОТООД СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ, СТРАТЕГИЙН ТОМЪЁОЛОЛ

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын стратеги төлөвлөгөөг боловсруулах багийнхан гадаад, дотоод орчныг шинжилж дараах хүчин зүйлсийг тодорхойлсон. Үүнд:

1. Гадаад орчны 58 боломж,
2. Гадаад орчны 100 аюул бэрхшээл,
3. Дотоод орчны 60 давуу тал,
4. Дотоод орчны 119 сул талыг тодорхойлсон болно.

Удирдлага, мэргэжилтнүүд, хамт олны уулзалт хэлэлцүүлэг, макро, микро орчны судалгааны үр дүнд нийт 337 хүчин зүйлсийг тодорхойлсон болно. Эдгээр хүчин зүйлсийг “Барилгын Хөгжлийн Төв” ТӨҮГ-ын мэргэжилтнүүд экспертүүдийн оролцоотой шинжилгээний аргаар тодорхойлов.



Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын хувьд **“Сул талаа арилгаж, боломжийг хүртэх замаар салбарын бодлогыг хэрэгжүүлэх”** стратегийн томъёолол тодорхойлогдлоо.

6.2 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ХЭЛТЭС НЭГЖ ТУС БҮРИЙН ХАМГИЙН ЧУХАЛ ГОЛ 5 ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын хувьд нийт 11 хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 337 хүчин зүйлсийг шинжилж үзсэн бол 196 хүчин зүйлийг илүү хамааралтай гэж үзжээ. Эдгээрээс дараах хүснэгтэд хамгийн чухал 55 хүчин зүйлсийг тодорхойлсон болно.

Хүснэгт 10. Хамгийн чухал хүчин зүйлсийн шинжилгээ

№	Үйл ажиллагааны чиглэл	Хамгийн чухал нөлөөлөх хүчин зүйлс
1	Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс	1. Баталгаажуулах явцад хөндлөнгөөс нөлөөлөх гэж оролддог 2. Барилгын зураг төсөл норм дүрэм лаборатори, барилгын материал, санхүүжилт гэх мэт бусад хэлтсийн үйл ажиллагаанд чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг. 3. Ажилтны эрүүл аюулгүй байдлыг хангаж ажилладаггүй. 4. Гадаадын зээл тусламжийн санхүүжилтэй учраас хятад ажилтан ихтэй, хэл нэвтрэлцэх асуудал гардаг. 5. Ажлын давхардал, цалгардал, хаягдах, үйл ойлголцол байнга үүсдэг
2	Барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори	1. Барилгын материалын шинжилгээ сорилын үйл ажиллагааны 40%-ийг дангаараа хийж байна. 2. Харилцагч нар дээжээ дутуу авч ирдэг 3. 21 аймгийн шинжээч нарыг лабораториудыг тоног төхөөрөмж дээр шинжилгээ хийлгэж, сургаж дадлагажуулж байнга хамтарч ажилладаг. Мэдлэг чадварыг нь дээшлүүлдэг. 4. Тоос шороо ихтэй учир харшилтай болох, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлалтай. 5. Мэргэжлийн ур чадвар сайтай хүмүүс ажилладаг.
3	Нийтийн аж ахуйн хэлтэс	1. Орон нутгийн инженер дэд бүтцийн найдвартай тасралтгүй байлгах шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх машин механизм, тоног төхөөрөмж сайжруулах 2. Хяналт, ашиглалтын үйл ажиллагаа давхар хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгоход тодорхой түвшинд оролцдоггүй 3. Тариф бага учраас өөрийгөө санхүүжүүлэх боломжгүй. 4. Статус тодорхой биш байдал 2012 оноос хойш үүссэн. Ажиллагсдын ажлын чанар бүтээмжийн чанар муу, ажлын зохион байгуулалт тааруу. 5. Улсын хэмжээнд инженерийн дэд бүтцийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэхэд судалгаа хугацаандаа ирдэггүй нь хүндрэл үүсгэдэг.
4	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс	1. Импортоор орж буй барилгын материал дээр 100% тохирлын гэрчилгээ олгодоггүй. Тухайн орны гарал үүслийн гэрчилгээ хуурамч байх тохиолдол байна 2. Нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байхгүй 3. Барилга байгууламжийг бүрэн паспортжуулснаар /газар хөдлөлтийн/ ХАБЭА-ын хяналт сайжирна. 4. Барилгын салбарын мэдээллийн санг цахимжуулсанаар шаардлагатай мэдээлэл, судалгаа байршил харгалзахгүйгээр авах ашиглах боломжтой. 5. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг МБҮА зохион байгуулдаг.
5	Зураг төслийн хяналтын хэлтэс	1. Хамтын ажиллагааны чадварыг сайжруулах, сургалт хөтөлбөрт хамрагдах боломжтой 2. Тендерийн тухай хуулийн хугацаанд багтаж гэрээ баталгааждаггүй. Яамнаас гэрээ байгуулах зөвлөмж ирэхдээ хугацаа давчуу ирдэг. 3. Олон хүнтэй харьцаж байгаа учир туршлага хуримтлуулж байна 4. Архитектур төлөвлөлтийн даалгаврын хүсэлтийг /Нийслэл & ОН/ баталгаажуулахад ажлын уялдаа холбоогүй ажилладаг. 5. Зураг төсөлд захиалагчийн хяналт гэсэн зардал тусгаагүй байдаг.

6	Бүс нутаг, хот суурин төлөвлөлтийн хэлтэс	1. Төслийг гүйцэтгэх төсөвт өртөг боломжтой өндөр тавигдсан. 2. Төсөл улс төрийн хүчин зүйлээс шалтгаалж батлагдахгүй байх магадлалтай. 3. Олон төрлийн мэргэжилтэй ажилтнууд байдаг ба мэргэжилтнүүдийн хийж буй мэргэжлийн судалгааны ажлыг байгууллага ойлгодоггүй. 4. Төслийг олон нийтэд танилцуулах мэдээлэх байдал муу. 5. Монгол улсын хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй аймаг орон нутаг бүр хангалттай нэг стандарт байхгүйн улмаас мэдээллийн бүрдэл харилцан адилгүй ирдэг.
7	Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс	1. ХАБЭА-ын жишиг танхимтай нь сургалтыг дадлага, онолыг хослуулан хийх боломж бүрдсэн. Тухайн чиглэлээр сургалтын хүрээг тэлэх боломжтой. 2. Төрийн байгууллага дэргэдээ хэвлэл мэдээллийн байгууллагатай байж болдоггүй. 3. Нэгдсэн судалгааг хийхдээ зөвхөн тоон мэдээлэлд тулгуурладаг учраас үр дүн муутай, цогц судалгаа байж чаддаггүй. 4. Зөвхөн мэдээллийн чанартай. ШУ-ы онол арга зүйн ололтын мэдээлэл хомс байдаг. 5. Салбарын хэмжээний статистик тоо баримтыг тус хэлтсээс гаргаж буй тоон мэдээлээс баримжаалдаг.
8	Норм, нормативын хэлтэс	1. Эрдэм шинжилгээний байгууллага байгуулах шаардлагатай. 2. Боловсруулж байгаа норм дүрэм шаардлага хангахгүй, хоцрогдож байна. 3. Барилгын салбарын бодлого тодорхойлоход оролцдог, оюунлаг, шинжлэх ухааны дэвшилтэт техник, технологи, онолыг салбарт нэвтрүүлэхэд тэргүүн эгнээнд ажилладаг. 4. Залуу боловсон хүчнийг урамшуулах, дэмжлэг үзүүлэх хөшүүрэг байхгүй. 5. Норм, норматив боловсруулах үйл ажиллагааг бараа бүтээгдэхүүн худалдан авах хуультай нэгэн адил хуулиар зохицуулагддаг тул мэргэжлийн зөвлөх үйлчилгээний утга нь алдагдсан.
9	Барилга, байгууламжийн зураг төсөл, магадлалын хэлтэс	1. Хүйтний улиралд УБЦТС, УБДС зэрэг байгууллагууд техникийн нөхцөл олгодоггүй байдлыг бодлогын хүрээнд шийдэх боломжтой. 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай барилгын зураг төслийн үнэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд суусан байдаг тул гэрээнээс магадлалын үнэ тооцохоос өөр аргагүй, энэ талаар дүрэм журам байдаггүй. 3. Магадлалын үйл ажиллагаа төрийн хяналтад байдаг. 4. Ажлын байранд мэргэжлийн чиглэлээр орон тоо дутмаг. 5. Хугацаа алдах, чадваргүй зургийн компани сонговол хүндрэл их учирдаг.
10	Захиргаа, удирдлагын хэлтэс	1. Хамтран ажиллагч байгууллагуудын дэмжлэгийг авах боломжтой. 2. Улс төрийн оролцоо их байдаг. 3. Санхүүгийн хувьд хараат бус буюу олсон орлогоор санхүүждэг. 4. Ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан. 5. Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хангалтгүй.
11	Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс	1. Улс төр, эдийн засгийн нөлөөллөөс хамаарч тогтвортой байдал алдагддаг. 2. Зардлыг зөв зохимжтой хянах шаардлагатай. 3. Төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломжтой. 4. Тасралтгүй хөгжих сурах боломжтой. 5. Багийн үйл ажиллагаа сул.

БҮЛЭГ 7. “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ХЭЛТЭС НЭГЖҮҮДИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын хувьд нийт 11 хэлтсийн 55 хүчин зүйлсийн гол утгыг авч үзвэл дараах утгуудтай байгаа бөгөөд эдгээрт тулгуурлан үнэт зүйлсийг тодорхойлсон.

Дараах хүснэгтээр харуулав.

7.1 “БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ХЭЛТСҮҮДИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

Хүснэгт 11. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ хэлтсүүдийн үнэт зүйлс

№	Үйл ажиллагааны чиглэл	Хамгийн чухал 5 гол утгад тулгуурласан үнэт зүйлс
1	Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтэс	1. Мэргэжлийн ур чадвар 2. Баталгаажуулалт 3. Олон талын мэдлэг шаардлагатай 4. Ажлын нөхцөл, хангалт 5. Ажилтны залгамж халаа
2	Барилгын материалын сорилт, шинжилгээний лаборатори	1. Зах зээлд манлайлагч 2. Харилцагчийг мэдээлээр хангах 3. Улсын хэмжээнд мэргэжлийн зөвлөгөө үзүүлдэг 4. Ажлын нөхцөл 5. Ур чадвар сайтай ажилтан
3	Нийтийн аж ахуйн хэлтэс	1. Улсын хэмжээний нийтийн аж ахуйн нэгдсэн бодлого 2. Эрдэм шинжилгээний байгууллага 3. Өөрийгөө санхүүжүүлэгч 4. Шинэ дэвшилтэт технологид тулгуурласан бүтээмж 5. Нэгдсэн мэдээллийн сан
4	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтэс	6. Мэргэжлийн мэдлэг ур чадвар 7. Зөв харилцаа хандлага 8. Барилга, барилгын материалын чанар аюулгүй байдал 9. Ил тод нээлттэй, хурдан шуурхай шударга байдал 10. Барилгын материалын нэгдсэн бүртгэл
5	Зураг төслийн хяналтын хэлтэс	1. Сургалт, хөтөлбөр 2. Иж бүрэн материал 3. Туршлага 4. Ажлын уялдаа холбоо 5. Төсөв мөнгө
6	Бүс нутаг, хот суурин төлөвлөлтийн хэлтэс	1. Төсөвт өртөг 2. Улс төрийн нөлөө 3. Олон төрлийн ур чадвартай мэргэжилтнүүд 4. Зөвлөх мэргэжилтэн 5. Нэгдмэл мэдээллийн сан
7	Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс	6. Сургалтын чанар 7. Хууль журмын хүрээнд ажиллах 8. Нэгдсэн судалгаа 9. Эмхэтгэлийг ШУ-ы бүтээл болгох 10. Статистик тоо баримт
8	Норм, нормативын хэлтэс	1. Эрдэм шинжилгээний байгууллага 2. Шинэ технологи, норм 3. Дэвшилтэт технологи 4. Боловсон хүчин 5. Эрх зүйн орчин
9	Барилга, байгууламжийн зураг төсөл, магадлалын хэлтэс	1. Техникийн нөхцөл 2. Дүрэм журмыг боловсронгуй болгох 3. Төрийн хяналт 4. Чадварлаг хүний нөөц 5. Чадвартай гүйцэтгэгч компани

10	Захиргаа, удирдлагын хэлтэс	1. Хамтран ажиллагсдын дэмжлэг 2. Төрийн оролцоо 3. Орлогоор цалинждаг 4. Ажлын бүтээмж 5. Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар
11	Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс	1. Улс төрийн нөлөө 2. Зардлын хяналт 3. Төсвийн үр ашигтай байдал 4. Сурч хөгжих боломж 5. Багийн ажиллагаа

